# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

№ 11 (440)

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

- *Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай*

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

- *Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр (2002-2010)-ийн зорилтыг хангах хоёр дахь шатны үйл ажиллагааны чиглэл батлах тухай*

Улсын Их Хурлын Тамгын газар
Улаанбаатар хот
2006 он

# ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ
Долоо хоног тутмын

Улаанбаатар хот | 2006 оны гуравдугаар сарын 21 | №11 (440)

## Гарчиг

### Нэг. МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ


| | | | |
|---|---|---|---|
| 162. | Чогсомын Балдарт Монгол Улсын ардын эмч цол хүртээх тухай | Дугаар 57 | 286 |
| 163. | Султаниягийн Магаунияд Монгол Улсын ардын уран зохиолч цол хүртээх тухай | Дугаар 58 | 286 |
| 164. | Лувсандашийн Нямаад Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээх тухай | Дугаар 59 | 286 |
| 165. | Хурбанбайн Уэбенд Монгол Улсын гавьяат холбоочин цол хүртээх тухай | Дугаар 60 | 286 |
| 166. | Даржаагийн Сүрэнхорлоод Монгол Улсын гавьяат нисгэгч цол хүртээх тухай | Дугаар 61 | 287 |
| 167. | Санжаадамбын Сайнцогт Монгол Улсын үйлчилгээний гавъяат ажилтан цол хүртээх тухай | Дугаар 62 | 287 |
| 168. | Батын Түмэнд Монгол Улсын гавъяат багш цол хүртээх тухай | Дугаар 63 | 287 |
| 169. | Маулетын Зулькафильд Монгол Улсын соёлын гавъяат зүтгэлтэн цол хүртээх тухай | Дугаар 64 | 287 |
| 170. | Майдаржавын Ганзоригт Монгол Улсын шинжлэх ухааны гавъяат зүтгэлтэн цол хүртээх тухай | Дугаар 65 | 287 |
| 171. | Дүгэрийн Рэгдэлд Монгол Улсын шинжлэх ухааны гавъяат зүтгэлтэн цол хүртээх тухай | Дугаар 66 | 288 |
| 172. | Однайн Бахытад Монгол Улсын гавъяат тамирчин цол хүртээх тухай | Дугаар 67 | 288 |
| 173. | Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай | Дугаар 68 | 288 |
| 174. | Зарим хүмүүсийг шүүгч, еренхий шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай | Дугаар 70 | 292 |
| 175. | Зарим хүмүүсийг аймаг, Нийслэлийн шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай | Дугаар 71 | 292 |
| 176. | Зарим хүмүүсийг сум дунд, дүүргийн шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай | Дугаар 72 | 292 |
| 177. | Зарим хүмүүсийг анхан шатны шүүхийн шүүгч, ерөнхий шүүгчийн албан тушаалд томилох тухай | Дугаар 73 | 293 |
| 178. | Шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх тухай | Дугаар 74 | 293 |
| 179. | Т. Уранцэцэгийг Ерөнхий шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай | Дугаар 75 | 293 |


### Хоёр. МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ


| | | | |
|---|---|---|---|
| 180. | Үйл ажиллагааны чиглэл батлах тухай | Дугаар 226 | 293 |
| 181. | Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр (2002-2010 он)-ийн зорилтыг хангах хоёр дахь шатны үйл ажиллагааны чиглэл батлах тухай | Дугаар 4 | 299 |
| 182. | Хөтөлбөрийг хэрэгжүүлэх II шатны үйл ажиллагааны үндсэн чиглэл батлах тухай | Дугаар 5 | 309 |
| 183. | Журамд өөрчлөлт оруулах тухай | Дугаар 9 | 312 |


### Гурав. МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ


| | | | |
|---|---|---|---|
| 184. | Монгол Улсын засгийн газрын 2005 оны 209 дүгээр тогтоолын 3 дахь заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай | Дугаар 2/02 | 312 |

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 3 дугаар сарын 16-ны өдөр | Дугаар 57 | Улаанбаатар хот

**Чогсомын Балдарт Монгол Улсын ардын эмч цол хүртээх тухай**

Эрүүл мэндийн болон батлан хамгаалахын салбарт олон жил үр бүтээлтэй ажиллаж мэс заслын эмчилгээний шинэ аргуудыг эмнэлгийн практикт нэвтрүүлэн зэвсэгт хүчний бие бүрэлдэхүүний эрүүл мэндийг хамгаалах, эмч, мэргэжилтний боловсрол, мэдлэгийг дээшлүүлэх, дадлагажуулан сургахад оруулж байгаа дорвитой хувь нэмрийг нь үнэлж Зэвсэгт хүчний жанжин штабын мэс заслын ерөнхий мэргэжилтэн Чогсомын Балдарт Монгол Улсын ардын эмч цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 3 дугаар сарын 16-ны өдөр | Дугаар 58 | Улаанбаатар хот

**Султаниягийн Магауияад Монгол Улсын ардын уран зохиолч цол хүртээх тухай**

Хэвлэл, мэдээллийн байгууллагад он удаан жил үр бүтээлтэй ажиллаж казах, монгол хэлээр үргэлжилсэн үгийн болон яруу найргийн бүтээлүүд туурвиж, монголын зохиолчдын олон бүтээлийг казах хэлнээ орчуулж, казахын ард түмний оюуны санг баяжуулахад оруулж байгаа дорвитой хувь нэмрийг нь үнэлж зохиолч, сэтгүүлч, орчуулагч Султаниягийн Магауияад Монгол Улсын ардын уран зохиолч цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 3 дугаар сарын 16-ны өдөр | Дугаар 59 | Улаанбаатар хот

**Лувсандашийн Нямаад Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээх тухай**

Дүрэмт хувьцасны оёдлын үйлдвэрт оёдолчин, бригадын дарга, мастераар олон жил үр бүтээлтэй ажиллаж хариуцсан тасгийн хамт олныг чадварлаг зохион байгуулан үйлдвэрлэлийн захиалга, даалгаврыг тоо, чанарын өндөр үзүүлэлттэйгээр биелүүлж, хэрэглэгчдийн хэрэгцээг найдвартай хангахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Дүрэмт хувцасны оёдлын "Бөртэ" үйлдвэрийн мастер Лувсандашийн Нямаад Монгол Улсын аж үйлдвэрийн гавьяат ажилтан цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 3 дугаар сарын 16-ны өдөр | Дугаар 60 | Улаанбаатар хот

**Хурманбайн Үзбенд Монгол Улсын гавьяат холбоочин цол хүртээх тухай**

Орон нутгийн үйлчилгээний байгууллагуудад олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж холбооны байгууллагын материаллаг баазыг бэхжүүлэх, холбоо, мэдээллийн цэг, салбарууд шинээр байгуулж, үйлчилгээний нэр төрлийг олшруулан, хүртээмжийг дээшлүүлэх, ажилгүйдлийг бууруулахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Баян-Өлгий аймгийн Холбооны газрын дарга Хурманбайн Үзбенд Монгол Улсын гавьяат холбоочин цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 3 дугаар сарын 16-ны өдөр | Дугаар 61 | Улаанбаатар хот

**Даржаагийн Сүрэнхорлоод Монгол Улсын гавьяат нисгэгч цол хүртээх тухай**

Иргэний нисэхийн салбарт олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж Зөвлөлт-Монголын хамтарсан сансрын нисгэгт бэлтгэх, салбарын эрх зүйн орчинг бүрдүүлэх, нисгэгч, инженер техникийн ажилчдыг сургаж дадлагажуулан, нисгэгийн ур чадварыг нэмэгдүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж "Буянт-Ухаа трейд" ХХК-ийн ерөнхий захирал Даржаагийн Сүрэнхорлоод Монгол Улсын гавьяат нисгэгч цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 3 дугаар сарын 16-ны өдөр | Дугаар 62 | Улаанбаатар хот

**Санжаадамбын Сайнцогт Монгол Улсын үйлчилгээний гавьяат ажилтан цол хүртээх тухай**

Төрийн болон төрийн бус байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж Монгол-Зөвлөлтийн хамтарсан сансрын нисгэгт бэлтгэх, залуучуудад цэрэг-эх оронч үзэл төлөвшүүлэх, олон улсын нисэх буудлын аюулгүй байдлыг хангахад оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Буянт-Ухаа дахь "Чингис хаан" олон улсын нисэх буудлын дэд дарга Санжаадамбын Сайнцогт Монгол Улсын үйлчилгээний гавьяат ажилтан цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 3 дугаар сарын 16-ны өдөр | Дугаар 63 | Улаанбаатар хот

**Батын Түмэнд Монгол Улсын гавьяат багш цол хүртээх тухай**

Батлан хамгаалахын их сургуулийн багш, тэнхмийн эрхлэгч, дэд захирлаар олон жил үр бүтээлтэй ажиллан сонсогчдод цэргийн хэргийн мэдлэг, тайван болон байлдааны цагт анги, салбарыг удирдах дадлага олгох, эрдэм судлалын бүтээлүүд туурвиж цэргийн шинжлэх ухааныг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж БХИС-ийн харьяа Батлан хамгаалахын удирдлагын академийн тэнхмийн эрхлэгч Батын Түмэнд Монгол Улсын гавьяат багш цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 3 дугаар сарын 16-ны өдөр | Дугаар 64 | Улаанбаатар хот

**Маулетын Зулькафильд Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай**

Боловсролын салбарт олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж эрдэм судлалын бүтээлүүд туурвиж, сэтгүүл зүйн онолын сэтгэлгээг хөгжүүлэх, сургалтын арга зүй, технологийг боловсронгуй болгон, мэргэжлийн сэтгүүлчид бэлтгэх, сэтгүүлчдийн байгууллагыг бэхжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж МУИС-ийн Нийгмийн шинжлэх ухааны сургуулийн сэтгүүл зүйн тэнхмийн эрхлэгч Маулетын Зулькафильд Монгол Улсын соёлын гавьяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

2006 оны 3 дугаар сарын 16-ны өдөр | Дугаар 65 | Улаанбаатар хот

**Майдаржавын Ганзоригт Монгол улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай**

Шинжлэх ухааны салбарт олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж Зөвлөлт-Монголын хамтарсан сансрын нисгэгийн багт ажиллаж, эрдэм судлалын бүтээлүүд туурвиж, Интеркосмос болон үндэсний сансар судлалыг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь

нэмрийг нь үнэлж ШУА-ийн Информатикийн хүрээлэнгийн захирал Майдаржавын Ганзоригт Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2006 оны 3 дугаар сарын 16-ны өдөр** **Дугаар 66** **Улаанбаатар хот**

### Дүгэрийн Рэгдэлд Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн цол хүртээх тухай

Шинжлэх ухааны салбарт олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж Зөвлөлт-Монголын сансрын хамтарсан нислэгийн эрдэм шинжилгээний хөтөлбөрийг хэрэгжүүлэх, эрдэм судлалын бүтээлүүд туурвиж манай улсад сансрын биологи, анагаах ухааны салбарыг хөгжүүлэхэд оруулж байгаа хувь нэмрийг нь үнэлж Шинжлэх ухааны академийн эрдэмтэн нарийн бичгийн дарга Дүгэрийн Рэгдэлд Монгол Улсын шинжлэх ухааны гавьяат зүтгэлтэн цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2006 оны 3 дугаар сарын 16-ны өдөр** **Дугаар 67** **Улаанбаатар хот**

### Однайн Бахытад Монгол Улсын гавьяат тамирчин цол хүртээх тухай

Биеийн тамир, спортын байгууллагад олон жил үр бүтээлтэй ажиллаж чөлөөт, үндэсний бөхийн барилдаанаар олимп, дэлхий, тивийн болон улсын аварга шалгаруулах тэмцээнд удаа дараа амжилттай оролцон алт, мөнгө, хүрэл медаль хүртэж спорт, хөдөлмөрийн өндөр амжилт гаргасныг үнэлж Баян-Өлгий аймгийн Биеийн тамир, спортын хорооны дарга, улсын харцага Однайн Бахытад Монгол Улсын гавьяат тамирчин цол хүртээсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2006 оны 3 дугаар сарын 16-ны өдөр** **Дугаар 68** **Улаанбаатар хот**

### Зарим хүнийг одон, медалиар шагнах тухай

Зэвсэгт хүчин, сансар судлал, үйлдвэрлэл, үйлчилгээ, хөдөө аж ахуй, боловсрол, соёл, шинжлэх ухаан, уул уурхай, хэвлэл мэдээлэл болон төр захиргааны байгууллагад олон жил санаачилга, үр бүтээлтэй ажиллаж байгаа дор дурдсан хүмүүсийг одон, медалиар шагнасугай.

**ХӨДӨЛМӨРИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:**

1. Кадены Акрас - Баян-Өлгий аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга
2. Дакейн Мугаз - Баян-Өлгий аймгийн Сагсай сумын 2 дугаар багийн малчин
3. Гарамжилын Орсоо - БХЯ-ны харьяа дүрэмт хувцасны оёдлын "Бөртэ" ТӨҮГ-ын эсгүүрчин
4. Дугаржавын Борчулуун - Нийслэл дэх шинжлэх ухаан, технологийн "Технотранс Консалтинг" ХХК-ийн захирал

**ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ УЛААН ТУГИЙН ОДОНГООР:**

1. Равдангийн Авирмэд - БХИС-ийн Ахлагчийн сургуулийн захирал, хурандаа
2. Сүрэнгийн Баасанхүү - БХЯ-ны Төрийн нарийн бичгийн дарга, хошууч генерал
3. Хишигтийн Зоригт - ЗХЖШ-ын Захиргаа, удирдлагын хэлтсийн ахлах мэргэжилтэн, дэд хурандаа
4. Рустемийн Канад - Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн артиллерийн дарга, хурандаа
5. Бандийн Цагаан - Зэвсэгт хүчний 256 дугаар ангийн артиллерийн дарга, хурандаа
6. Цамбын Цогтжаргал - ЗХЖШ-ын Артиллерийн хэлтсийн дарга, хурандаа
7. Дашзэвэгийн Цэрэндагва - Өвөрхангай аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга, хурандаа

**"АЛТАН ГАДАС" ОДОНГООР:**

1. Азыханы Авдрахман - Ховд аймгийн Мянгад сумын Баянхошуу багийн тариаланч
2. Тахаугийн Ашим - Баян-Өлгий аймгийн Мэргэжлийн хяналтын газрын улсын ахлах байцаагч
3. Агыпарын Бакей - Монгол Улсын Их Хурлын гишүүн
4. Жанабилханы Бакель - Баян-Өлгий аймгийн Цэнгэл сум дахь хөдөө аж ахуйн "Бай-Бол" хоршооны нягтлан бодогч
5. Хызылын Барбол - Баян-Өлгий аймгийн Өлгий сум дахь "Арлан" хоршооны дарга
6. Галбадрахын Ганзориг - Нийслэлийн ЗДТГ-ын Цэргийн штабын тоо бүртгэл, нууцын офицер, дэд хурандаа
7. Лхамын Должин - БХЯ-ны харъяа дүрэмт хувцасны оёдлын "Бөртэ" ТӨҮГ-ын оёдолчин
8. Хабаны Доман - Баян-Өлгий аймгийн Засаг даргын дэргэдэх Хүүхдийн төлөө төвийн дарга
9. Хуанганы Еркетай - Баян-Өлгий аймгийн Алтай сумын ИТХТ-ийн дарга
10. Дашцэрэнгийн Жаргалсайхан - БХЯ-ны харъяа дүрэмт хувцасны оёдлын "Бөртэ" ТӨҮГ-ын мастер
11. Тампены Кекей - Баян-Өлгий аймгийн Ногооннуур сумын ИТХТ-ийн дарга
12. Тилеужаны Махай - Баян-Өлгий аймаг дахь Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн мастер багш
13. Идолдагийн Мерейхан - Баян-Өлгий аймгийн Өлгий сум дахь ахлах 3 дугаар сургуулийн эд хариуцагч
14. Хайротын Монголхаан - Нийслэлийн Налайх дүүргийн өндөр настан, худалдааны байгууллагын ахмад ажилтан
15. Лувсанвандангийн Оюунбилэг - ШУА-ийн Физик, техникийн хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан
16. Жардыханы Сезимхан - Баян-Өлгий аймгийн Сагсай сумын дунд сургуулийн дотуур байрны менежер
17. Хасымын Телеухан - Нийслэлийн Баянгол дүүргийн өндөр настан, эрчим хүчний ахмад ажилтан
18. Шегирткегийн Тилеубек - Баян-Өлгий аймгийн Өлгий сум дахь үйлдвэрлэл, үйлчилгээний "Тасты-булак" хоршооны захирал
19. Садугийн Хызырбек - Баян-Өлгий аймаг дахь "Алтынгео" ХХК-ийн зөвлөх геологич

**ЦЭРГИЙН ГАВЬЯАНЫ ОДОНГООР:**

1. Гомбын Баатарнум - Зэвсэгт хүчний "Соёмбо" сонины сурвалжлагч, хошууч
2. Хажейн Базар - Зэвсэгт хүчний 014 дүгээр ангийн химийн дарга, хошууч
3. Учралын Бат-Эрдэнэ - Дотоодын цэргийн 05 дугаар ангийн захирагч, хурандаа
4. Батцэнгэлийн Ганбаатар - ЗХЖШ-ын Ар талын газрын Материал хангалтын хэлтсийн дарга, хурандаа
5. Аюушийн Ганбат - ЗХЖШ-ын Сургалт, зохион байгуулалт эрхэлсэн орлогч дарга, хошууч генерал
6. Мөнхдоржийн Ганбат - Зэвсэгт хүчний 089 дүгээр ангийн жолооч, ахлах ахлагч
7. Жигжидсүрэнгийн Ганхүү - БХИС-ийн Цэргийн дээд сургуулийн тэнхмийн дарга, хурандаа
8. Бэгзийн Даваадорж - БХЯ-ны Бодлого төлөвлөлт, гадаад хамтын ажиллагааны газрын ахлах мэргэжилтэн, хурандаа
9. Лувсанзэвгийн Даваасамбуу - Төв аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабын офицер, дэд хурандаа
10. Гомбын Жаргалсайхан - Зэвсэгт хүчний 327 дугаар ангийн инженерийн дарга, хошууч
11. Гончигдоржийн Нямдорж - Зэвсэгт хүчний "Соёмбо" сонины орлогч эрхлэгч, дэд хурандаа
12. Төмөрхуягийн Өлзийбаяр - Зэвсэгт хүчний 089 дүгээр ангийн жолооч, ахлах ахлагч
13. Гүрсэдийн Сайханбаяр - БХЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газрын дарга, хурандаа
14. Жигжидсүрэнгийн Сүхбаатар - Дорнод аймгийн ЗДТГ-ын Цэргийн штабын дарга, хурандаа
15. Жамъянгаравын Хүрэлбаатар - Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн зэвсгийн дарга, дэд хурандаа
16. Батдондогийн Цэвээн - Зэвсэгт хүчний 011 дүгээр ангийн ерөнхий механикийн тасгийн дарга, хошууч
17. Рэнцэндоржийн Цэрэнням - БХИС-ийн сургалтын бодлого, зохицуулалтын албаны арга зүйч багш, дэд хурандаа
18. Шийлэгийн Энхбат - Зэвсэгт хүчний 065 дугаар ангийн захирагч, хурандаа
19. Жүгдэрийн Энхбаяр - БХИС-ийн Батлан хамгаалах эрдэм шинжилгээний хүрээлэнгийн эрдэм шинжилгээний ажилтан, хурандаа

**ХӨДӨЛМӨРИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:**

1. Тилеуханы Айжан - Баян-Өлгий аймгийн Өлгий сум дахь нүүрсний "Хотгор" ХК-ийн нягтлан бодогч
2. Жанчивын Алимаа - БХИС-ийн Сургалтын бодлого, зохицуулалтын албаны диспетчер багш
3. Цэрэндашийн Ачмаа - Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн нягтлан бодогч

4. Лувсанбалдангийн Баатар - Зэвсэгт хүчний 089 дүгээр ангийн жолооч

5. Даваажамцын Бира - Зэвсэгт хүчний 013 дугаар ангийн нягтлан бодогч

6. Гантөмөрийн Даваажав - Цэргийн дуу, бүжгийн эрдмийн чуулгын үйлчлэгч

7. Нямдоржийн Даваажанцан - Зэвсэгт хүчний 310 дугаар ангийн уурын зуухны механикч

8. Рэнцэндоржийн Долгормаа - БХЯ-ны харьяа дүрэмт хувцасны оёдлын "Бөртэ" ТӨҮГ-ын чанар шалгагч

9. Пүрэвдоржийн Дэнсмаа - Зэвсэгт хүчний 310 дугаар ангийн нягтлан бодогч

10. Сорогжавын Жавзмаа - Зэвсэгт хүчний 011 дүгээр ангийн инженерийн засварын цехийн нярав

11. Жиынбайн Канибат - "Баруун бүсийн цахилгаан дамжуулах сүлжээ" ХК-ийн Баян-Өлгий аймаг дахь салбарын ахлах инженер

12. Содномын Мэндсугар - БХЯ-ны харьяа дүрэмт хувцасны оёдлын "Бөртэ" ТӨҮГ-ын мастер

13. Дангаажавын Нармандах - Зэвсэгт хүчний Клиникийн төв эмнэлгийн үйлчилгээний албаны дарга

14. Чоймболын Оюунбилэг - Зэвсэгт хүчний 016 дугаар ангийн нягтлан бодогч

15. Суурийн Пүрэвням - Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн сувилагч

16. Хабигийн Санияз - Баян-Өлгий аймгийн Сагсай сумын 11 жилийн дунд сургуулийн физикийн багш

17. Елеукейн Сергажы - Баян-Өлгий аймгийн Толбо сумын 11 жилийн дунд сургуулийн нярав

18. Жаманы Тилеген - Баян-Өлгий аймгийн Улаанхус сумын Баянзүрхийн 5 дугаар багийн Засаг дарга

19. Мялдолгорын Тунгалаг - БХЯ-ны харьяа дүрэмт хувцасны оёдлын "Бөртэ" ТӨҮГ-ын оёдолчин

20. Навааны Хүрэлтогоо - Зэвсэгт хүчний 032 дугаар ангийн кино-радио механикч

**ЦЭРГИЙН ХҮНДЭТ МЕДАЛИАР:**

1. Жанчивын Амгалан - Дотоодын цэргийн штабын орлогч, хурандаа

2. Бужийновын Амгаланбаатар - БХИС-ийн дэд захирал, хурандаа

3. Нацагдоржийн Бадамханд - Зэвсэгт хүчний нэгдсэн лабораторийн хөдөлгөөнт лабораторийн дарга, ахлах ахлагч

4. Нямхүүгийн Батаа - Зэвсэгт хүчний 124 дүгээр ангийн удирдах байрны дарга, хошууч

5. Сангидоржийн Батболд - Зэвсэгт хүчний Агаарын довтолгооноос хамгаалах цэргийн командлалын ахлах мэргэжилтэн, дэд хурандаа

6. Бирваагийн Батмөнх- Зэвсэгт хүчний 336 дугаар ангийн ар талын материал хэрэгсэл хадгалах тасгийн инженер, ахмад

7. Өвгөнхүүгийн Батмөнх - БХЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газрын ахлах мэргэжилтэн, дэд хурандаа

8. Пүрэвийн Батнайрамдал - Зэвсэгт хүчний "Соёмбо"сонины ахлах сурвалжлагч, дэд хурандаа

9. Ганхавхын Бат-Орших - Зэвсэгт хүчний 303 дугаар ангийн захирагчийн 1 дүгээр орлогч, штабын дарга, дэд хурандаа

10. Даваажавын Батсайхан - Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн батальоны захирагч, дэд хурандаа

11. Пүрэвсүрэнгийн Батсэргэлэн - Дотоодын цэргийн 805 дугаар ангийн Ус суваг хамгаалах тусгай салбарын захирагч, хошууч

12. Бираабазарын Баттулга - Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн хуягт танкийн дарга, хошууч

13. Доржпаламын Баттөмөр - Зэвсэгт хүчний 186 дугаар ангийн байлдааны бэлтгэлийн дарга, хошууч

14. Алтангэрэлийн Баттулга - Нийслэлийн Сүхбаатар дүүргийн ЗДТГ-ын ЦИХШ-ын офицер, дэд хурандаа

15. Лхайжавын Баярсайхан - ЗХЖШ-ын Цэргийн тагнуулын газрын ахлах мэргэжилтэн, хурандаа

16. Монхооройн Баярхүү - Зэвсэгт хүчний 016 дугаар ангийн соёл, хүмүүжлийн дарга, дэд хурандаа

17. Цэрэннадмидын Болдбаатар - Зэвсэгт хүчний 337 дугаар ангийн захирагчийн орлогч, ерөнхий инженер,дэд хурандаа

18. Чогдонгийн Болдбаатар - БХИС-ийн Цэргийн дээд сургуулийн багш, дэд хурандаа

19. Нанжидын Бор - БХЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газрын ахлах мэргэжилтэн, дэд хурандаа

20. Нямбуугийн Бумцэнд - Зэвсэгт хүчний 167 дугаар ангийн захирагч, хурандаа

21. Александрын Бүрнээбаатар - ЗХЖШ-ын Иргэний хамгаалалтын хэлтсийн ахлах мэргэжилтэн, дэд хурандаа

22. Дашбямбын Бямбадагва - Дотоодын цэргийн 805 дугаар ангийн Ус суваг хамгаалах тусгай салбарын харуулчин, ахлах ахлагч

23. Мужааны Бямбасүрэн - Орхон аймаг дахь Дотоодын цэргийн 816 дугаар тусгай салбарын харуулчин, ахлах ахлагч

24. Дашзэвэгийн Ваня - ЗХЖШ-ын Ар талын газрын Авто хуягт, техникийн хэлтсийн ахлах мэргэжилтэн, ерөнхий инженер, дэд хурандаа

25. Төрөөгийн Ганбат - Зэвсэгт хүчний 325 дугаар ангийн захирагч, хурандаа

26. Шаравжамцын Ганбат - ЗХЖШ-ын Захиргаа, удирдлагын хэлтсийн туслах мэргэжилтэн, тэргүүн ахлагч

27. Дамдингийн Ганболд - Зэвсэгт хүчний 089 дүгээр ангийн жолооч, ахлах ахлагч

28. Цэрэнгийн Ганболд - Зэвсэгт хүчний 284 дүгээр ангийн захирагч, дэд хурандаа

29. Чойжилын Ганболд - Зэвсэгт хүчний 336 дугаар ангийн захирагчийн орлогч, хошууч

30. Довчинсүрэнгийн Ганзориг - ЗХЖШ-ын Энхийг сахиулах ажиллагааны газрын мэргэжилтэн, хошууч

31. Дамдинжавын Гансүх - ЗХЖШ-ын Мэдээллийн аюулгүй байдлыг хангах албаны мэргэжилтэн, дэд хурандаа

32. Хуягийн Гансүх - ЗХЖШ-ын Ар талын газрын материал хангалтын хэлтсийн мэргэжилтэн, дэд хурандаа

33. Далантайн Гантөмөр - Зэвсэгт хүчний 310 дугаар ангийн эмнэлгийн тоног төхөөрөмжийн техникч, ахлах ахлагч

34. Дуламсүрэнгийн Даваа - БХИС-ийн Цэргийн дээд сургуулийн тэнхмийн дарга, дэд хурандаа

35. Сүрэнхорлоогийн Дашзэвэг - Зэвсэгт хүчний 150 дугаар ангийн захирагчийн 1 дүгээр орлогч, штабын дарга, дэд хурандаа

36. Пүрэвийн Дондог - Зэвсэгт хүчний 016 дугаар ангийн ар талын даргын орлогч, дэд хурандаа

37. Содовын Доржготов - Зэвсэгт хүчний 015 дугаар ангийн штабын даргын дайчилгаа, жагсаал анги эрхэлсэн туслах, дэд хурандаа

38. Замандийн Жамъянчагнаа - БХИС-ийн Цэргийн дээд сургуулийн багш, дэд хурандаа

39. Пүрэвийн Жаргалсайхан - ЗХЖШ-ын Цэргийн сургалт, хүмүүжлийн хэлтсийн дарга, хурандаа

40. Түндэвийн Жаргалсайхан - ЗХЖШ-ын Инженерийн цэргийн хэлтсийн мэргэжилтэн, дэд хурандаа

41. Мялдоржийн Золзаяа - Зэвсэгт хүчний Холбоо, цэргийн удирдлагын автоматжуулалын хэлтсийн мэргэжилтэн, дэд хурандаа

42. Дэмбэрэлийн Зоригтсайхан - БХИС-ийн Цэргийн хөгжмийн коллежийн дэд захирал, тэнхмийн дарга, дэд хурандаа

43. Ядмаагийн Лхагважав - БХИС-ийн Цэргийн дээд сургуулийн бичиг хэргийн хөтлөгч, ахлах ахлагч

44. Лхагвасүрэнгийн Лхагвадорж - Зэвсэгт хүчний 011 дүгээр ангийн захирагчийн орлогч, ерөнхий инженер, дэд хурандаа

45. Нямсүрэнгийн Лхагвасүрэн - БХИС-ийн Батлан хамгаалахын удирдлагын академийн багш, дэд хурандаа

46. Даваанямын Мандахнар - БХЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газрын нууцын дарга, дэд сайдын туслах, ахлах ахлагч

47. Цэрэндагвын Мөнхбаатар - БХИС-ийн Цэргийн дээд сургуулийн дадлагын багш, ахлах ахлагч

48. Сумъяагийн Мөнхбаяр - Зэвсэгт хүчний 084 дүгээр ангийн захирагчийн орлогч, дэд хурандаа

49. Лувсанчүлтэмийн Мөнхдолгор - Зэвсэгт хүчний 016 дугаар ангийн станцын дарга, жолооч, ахлах ахлагч

50. Сосорбурамын Мөнх-Эрдэнэ - Зэвсэгт хүчний 124 дүгээр ангийн биеийн тамир, спортын дарга, ахмад

51. Балбарын Наянбуу - ЗХЖШ-ын Ар талын газрын гал түймэртэй тэмцэх албаны дарга, дэд хурандаа

52. Сангишаравын Оюунчимэг - ЦЕГ-ын санхүү,аж ахуйн газрын хөрөнгө оруулалтын ахлах мэргэжилтэн, цагдаагийн дэд хурандаа

53. Хишигдоржийн Өлзийбат - Зэвсэгт хүчний 189 дүгээр ангийн холбооны төв засварын дарга, дэд хурандаа

54. Цагааны Өнөрбаяр - ЗХЖШ-ын Үлгэр жишээ, үлээвэр найрал хөгжмийн хөгжимчин, группийн дарга, ахлах ахлагч

55. Бямбажавын Рагчаасүрэн - Зэвсэгт хүчний 314 дүгээр ангийн захирагчийн 1 дүгээр орлогч, штабын дарга, дэд хурандаа

56. Чүлтэмийн Рэнцэнбазар - БХИС-ийн санхүүгийн тасгийн дарга, ерөнхий санхүүч, дэд хурандаа

57. Тавхайн Соронзонболд - БХИС-ийн Сургалтын бодлого, зохицуулалтын албаны дарга, дэд хурандаа

58. Пүрэвийн Тамиргол - Зэвсэгт хүчний 011 дүгээр ангийн засварын хөдөлгөөнт бүлгийн дарга, дэд хурандаа

59. ЛхагвынТөмөрбаатар - Зэвсэгт хүчний 014 дүгээр ангийн захирагчийн орлогч, ар талын дарга, дэд хурандаа

60. Тогмын Төрбат - Зэвсэгт хүчний 120 дугаар ангийн ар талын даргын орлогч, дэд хурандаа

61. Сосорын Түвшинжаргал - Зэвсэгт хүчний 011 дүгээр ангийн захирагчийн орлогч, ар талын дарга, дэд хурандаа

62. Жамсрангийн Тэрбиш - Орхон аймаг дахь Дотоодын цэргийн 816 дугаар тусгай салбарын захирагчийн орлогч, хошууч

63. Гарьдын Үнэнбаяр - ЗХЖШ-ын Захиргаа, удирдлагын хэлтсийн мэргэжилтэн, ахлах дэслэгч

64. Жавзангийн Хүрэл - БХИС-ийн Цэргийн дээд сургуулийн багш, дэд хурандаа

65. Жалбуугийн Хүрэлхуяг - Дотоодын цэргийн 05 дугаар ангийн жолооч, ахлах ахлагч

66. Гомбосүрэнгийн Цагаанхүү - Зэвсэгт хүчний төв архивын орлогч дарга, дэд хурандаа

67. Довчингийн Цог-Эрдэнэ - Зэвсэгт хүчний "Алдар" спорт хорооны орлогч дарга, дэд хурандаа

68. Батаагийн Цогт-Очир - Зэвсэгт хүчний 336 дугаар ангийн холбооны техник хэрэгсэл хадгалах тасгийн дарга, хошууч

69. Пагвжавын Цэрэннадмид - Зэвсэгт хүчний 013 дугаар ангийн машины дарга жолооч, ахлах ахлагч

70. Дармаагийн Чипхаасүрэн - БХЯ, ЗХЖШ-ын Үйлчилгээ, аж ахуйн хэлтсийн нярав, ахлах ахлагч

71. Доржпаламын Энхбаатар - Зэвсэгт хүчний 336 дугаар ангийн зэвсгийн дарга, хошууч

72. Галсандоржийн Энхбилэг - БХИС-ийн Батлан хамгаалахын удирдлагын академийн номын санч, ахлах ахлагч

73. Очирдоржийн Эрдэнэбаатар - ЗХЖШ-ын Цэргийн тагнуулын газрын мэргэжилтэн, дэд хурандаа

74. Өндгөний Эрдэнэ-Очир - Зэвсэгт хүчний 123 дугаар ангийн захирагч, хурандаа

75. Содовын Эрдэнэтөгс - БХЯ-ны Мэдээлэл, хяналт шинжилгээ, үнэлгээний газрын ахлах мэргэжилтэн, дэд хурандаа

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2006 оны 3 дугаар сарын 20-ны өдөр** **Дугаар 70** **Улаанбаатар хот**

**Зарим хүмүүсийг шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай**

"Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 58 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 2 дахь заалтыг баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Төрийн өөр ажил, албан тушаалд томилогдох болсон Дашнямын Цогтсайханыг Дорноговь аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн, Цэвээндоогийн Өрнөндэлгэрийг Орхон аймгийн шүүхийн шүүгчийн, Лхагвын Энхтайванocc Сэлэнгэ аймгийн шүүхийн шүүгчийн, Батаагийн Батцэрэнг Нийслэлийн Сүхбаатар дүүргийн шүүхийн шүүгчийн, Намхайн Цогоог Дорнод аймаг дахь Хэрлэн сумын шүүхийн шүүгчийн, Сономдовчингийн Энхтөрийг Завхан аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн шүүгчийн, Дашдоржийн Мөнхөөг Завхан аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгчийн албан тушаалаас тус тус чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2006 оны 3 дугаар сарын 20-ны өдөр** **Дугаар 71** **Улаанбаатар хот**

**Зарим хүмүүсийг аймаг, Нийслэлийн шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай**

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 12 дугаар зүйлийн 16, "Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 32 дугаар зүйлийн 1 дэх заалтыг тус тус баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Намхайн Цогоог Дорнод аймгийн шүүхийн шүүгчийн, Сономдовчингийн Энхтөрийг Дундговь аймгийн шүүхийн шүүгчийн, Батаагийн Батцэрэн, Цэвээндоогийн Өрнөндэлгэр нарыг Нийслэлийн шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2006 оны 3 дугаар сарын 20-ны өдөр** **Дугаар 72** **Улаанбаатар хот**

**Зарим хүмүүсийг сум дунд, дүүргийн шүүхийн шүүгчийн албан тушаалд томилох тухай**

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 12 дугаар зүйлийн 16, "Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 32 дугаар зүйлийн 1 дэх заалтыг тус тус баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Цогийн Очийг Нийслэлийн Баянгол дүүргийн шүүхийн шүүгчийн, Төмөрбаатарын Өсөхбаярыг Нийслэлийн Баянзүрх дүүргийн шүүхийн шүүгчийн, Чагдаагийн Хосбаярыг Нийслэлийн Сүхбаатар дүүргийн шүүхийн шүүгчийн, Сосорбарамын Соёмбо-Эрдэнийг Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн шүүхийн шүүгчийн, Түмэн-Өлзийн Алтантуяаг Нийслэлийн Чингэлтэй дүүргийн шүүхийн шүүгчийн, Пагамын Туяатыг Нийслэлийн Хан-Уул дүүргийн шүүхийн шүүгчийн, Санги-Очирын Олзодыг Нийслэлийн Налайх дүүргийн шүүхийн шүүгчийн, Халамханы Мейрамбекийг Баян-

Өлгий аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн, Баасанжавын Эрдэнэхишигийг Сэлэнгэ аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгчийн, Бадамын Цагцалмааг Увс аймаг дахь сум дундын шүүхийн шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2006 оны 3 дугаар сарын 20-ны өдөр** **Дугаар 73** **Улаанбаатар хот**

**Зарим хүмүүсийг анхан шатны шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалд томилох тухай**

"Монгол Улсын Ерөнхийлөгчийн тухай" хуулийн 12 дугаар зүйлийн 16, "Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 32 дугаар зүйлийн 1, 4, 6 дахь заалтыг тус тус баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

1. Содовын Цэрэндуламыг Булган аймаг дахь сум дундын шүүхийн Ерөнхий шүүгчийн, Дашдоржийн Мөнхөөг Завхан аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн, Лхагвын Энхтайваныг Сэлэнгэ аймаг дахь сум дундын 1 дүгээр шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн, Дашнямын Цогтсайханыг Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн шүүхийн шүүгч, Ерөнхий шүүгчийн албан тушаалд тус тус томилсугай.

2. Гэрэлийн Тэгшсуурийг Дорноговь аймгийн шүүхийн Ерөнхий шүүгчийн, Гэндэндоржийн Болормааг Хэнтий аймаг дахь сум дундын 2 дугаар шүүхийн Ерөнхий шүүгчийн, Лувсандашийн Гансүхийг Нийслэлийн Налайх дүүргийн шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалд тус тус улируулан томилсугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2006 оны 3 дугаар сарын 20-ны өдөр** **Дугаар 74** **Улаанбаатар хот**

**Шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлэх тухай**

"Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 57 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 5, 78 дугаар зүйлийн 4 дэх заалтыг тус тус баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Баян-Өлгий аймаг дахь сум дундын шүүхийн шүүгч Тогтоолын Байгонакийг эрүүгийн хариуцлагад татах зөвшөөрөл олгож, Эрүүгийн байцаан шийтгэх хуульд заасны дагуу эрх бүхий байгууллагаас зохих шийдвэр гарах хүртэл шүүгчийн бүрэн эрхийг түдгэлзүүлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН ЗАРЛИГ

**2006 оны 3 дугаар сарын 20-ны өдөр** **Дугаар 75** **Улаанбаатар хот**

**Т.Уранцэцэгийг Ерөнхий шүүгчийн албан тушаалаас чөлөөлөх тухай**

"Шүүхийн тухай" Монгол Улсын хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх заалтыг баримтлан, Шүүхийн ерөнхий зөвлөлийн саналыг үндэслэн ЗАРЛИГ болгох нь:

Бүрэн эрхийн хугацаа дууссан тул Тогтохын Уранцэцэгийг Нийслэлийн Сонгинохайрхан дүүргийн шүүхийн Ерөнхий шүүгчийн албан тушаалаас чөлөөлсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙЛӨГЧ Н.ЭНХБАЯР**

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

**2005 оны 12 дугаар сарын 29-ний өдөр** **Дугаар 266** **Улаанбаатар хот**

**Үйл ажиллагааны чиглэл батлах тухай**

"Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогыг батлах тухай" Улсын Их хурлын 2004 оны 21 дүгээр тогтоолыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогыг 2006-2008 он хүртэл хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлийг хавсралт ёсоор баталсугай.

2. Монгол Улсын төрөөс хүн амын хөгжлийн талаар баримтлах бодлогыг 2006-2008 он хүртэл хэрэгжүүлэх үйл ажиллагааны чиглэлд тусгагдсан ажлыг Эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх жил бүрийн үндсэн чиглэлд тусган хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Үйл ажиллагааны чиглэлд тусгагдсан арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгийг жил бүрийн төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн багц болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх төслийн жагсаалтад оруулах замаар шийдвэрлэн ажиллахыг Сангийн сайд Н.Алтанхуяг, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Ц.Баярсайхан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Ц.ЭЛБЭГДОРЖ**

**НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН САЙД Ц.БАЯРСАЙХАН**

***Засгийн газрын 2005 оны 266 дугаар тогтоолын хавсралт***

## МОНГОЛ УЛСЫН ТӨРӨӨС ХҮН АМЫН ХӨГЖЛИЙН ТАЛААР БАРИМТЛАХ БОДЛОГЫГ 2006-2008 ОН ХҮРТЭЛ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

| № | Хэрэгжүүлэх арга хэмжээ | Хугацаа | Хариуцах байгууллага | Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлт | Шийдвэрлэх асуудлын товч агуулга |
|---|---|---|---|---|---|
| | Нэг. Эрх зүйн орчинг боловсронгуй болгох талаар | | | | |
| 1. | Хүн амын бүртгэл, мэдээллийн чанарыг сайжруулах, иргэн, албан тушаалтны үүрэг хариуцлагын асуудлаар Иргэний бүртгэлийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах | 2006-2008 он | Хууль зүй, дотоод хэргийн яам, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Үндэсний статистикийн газар | Хуулинд өөрчлөлт оруулсан байх | Хуулийн дагуу иргэний хөдөлгөөний бүртгэлээ хийлгээгүй иргэнд хариуцлага хүлээлгэх, засаг захиргааны нэгжид ажиллагсад иргэний бүртгэлийг сайжруулах талаар хүлээх үүрэг хариуцлагыг өндөржүүлэх асуудлыг тусгана. |
| 2. | Хүн амын өсөлтийг дэмжих, гэр бүлийн 3 дахь хүүхдэд урамшуулал олгох асуудлыг судалж санал боловсруулах | 2006-2007 он | Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Сангийн яам | Санал боловсруулсан байх | Хүн амын зохистой өсөлтийг дэмжихэд чиглэсэн гэр бүлийн 3 дахь хүүхдэд зориулсан урамшуулал бий болгох талаар санал боловсруулна. |
| 3. | Хүн амын нөхөн үржихүйн эрхийг хангах, эцэг, эхийн үүрэг, хариуцлагыг дээшлүүлэх талаар Гэр бүлийн тухай, Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах | 2006 оноос | Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Эрүүл мэндийн яам | Хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулсан байх | Хүн амын нөхөн үржихүйн эрхийг хангах, эрэгтэйчүүдийн үүрэг хариуцлага, оролцоог нэмэгдүүлэх, эцэг байх үүргээ хэрэгжүүлэх талаар хуульд тусгана. |
| 4. | Хөдөлмөр эрхэлдэг эхчүүдийн хүүхэд асарсны тэтгэмжийг ажилладаг байгууллагаас олгох талаар судалж, холбогдох хууль тогтоомжид өөрчлөлт оруулах санал боловсруулах | 2006-2008 он | Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Сангийн яам | Санал боловсруулсан байх | Хөдөлмөр эрхэлдэг эхчүүдийн хүүхэд асарсны тэтгэмжийг үе шаттайгаар нэмэгдүүлэх, ажил олгогчдын хүлээх үүргийн талаар судалж санал боловсруулна. |
| 5. | Эмэгтэйчүүд, хүүхдийг хүчирхийллийн бүх хэлбэрээс хамгаалах, тэднийг худалдах, биеэ үнэлэхийг албадах, хөлслөх үйл ажиллагаанд татагдан орохоос урьдчилан сэргийлэх үйл ажиллагаатай холбогдсон эрх зүйн зохицуулалтад судалгаа хийх | 2006 оноос | Хууль зүй, дотоод хэргийн яам, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам | Судалгаа хийсэн байх | Хүчирхийлэл, хүн худалдаалах, бэлгийн зорилгоор ашиглах асуудлыг хууль тогтоомжид хэрхэн тусгасныг судлан боловсронгуй болгох санал боловсруулна. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| Хоёр. Хүн амын гадаад шилжих хөдөлгөөний талаар | | | | | |
| 6. | Гадаадад ажиллах хүч гаргах, гадаадаас ажиллах хүч, мэргэжилтэн авах талаархи хууль, эрх зүйн орчинг боловсронгуй болгож, өндөр хөгжилтэй орнуудад албан ёсоор ажиллах хүчин гаргах, мэргэшүүлэх талаар хоёр талт гэрээ, хэлэлцээр байгуулах явдлыг өргөжүүлэх | 2006-2008 онд | Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Гадаад хэргийн яам | Шинээр гэрээ байгуулсан орны тоо нэмэгдсэн байх | АНУ, Англи, Франц зэрэг өндөр хөгжилтэй, монгол иргэд албан бусаар олноор ажилладаг орнуудад албан ёсоор ажиллах хүч гаргах асуудлыг судлан шийдвэрлэнэ. |
| 7. | Гадаадад ажиллаж, амьдарч байгаа монгол иргэдийн эрүүл мэнд, гэнэтийн ослын даатгалыг тухайн оронд нь, тэтгэвэр, тэтгэмжийн даатгалд эх орондоо хамрагдах асуудлыг Засгийн газар хоорондын гэрээ, хэлэлцээрт тусган хэрэгжүүлэх | 2006 онд | Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Гадаад хэргийн яам | Гадаадад ажиллаж амьдарч байгаа иргэд нийгмийн даатгалд хамрагдсан байх | Гадаадад ажиллаж, амьдарч байгаа иргэдийг нийгмийн даатгалд хамруулна. |
| 8. | Гадаадад ажиллуулах, сургах талаар гаргаж буй зар сурталчилгаанд мэргэжлийн болон хууль, хяналтын байгууллагатай хамтран хяналт тавих арга хэмжээ авах | 2006-2008 он | Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Хууль зүй, дотоод хэргийн яам, Гадаад хэргийн яам, Улсын мэргэжлийн хяналтын газар, Тагнуулын ерөнхий газар, Цагдаагийн ерөнхий газар | Хяналт шалгалт тогтмолжсон байх. Энэ талаархи иргэдийн өргөдөл гомдлын тоо буурсан байх | Гадаадад зуучлах зард хууртагдаж, хохирохоос сэргийлэх, хамгаалах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. |
| 9. | Гадаадад ажиллаж амьдарч буй монгол иргэдээс эх орныхоо эдийн засаг, нийгмийн хөгжилд хөрөнгө оруулахад дэмжлэг үзүүлэх web хуудсыг нээж, ажиллуулах | 2006 оноос | Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газар, яамд | Тухайн web site-д орж мэдээлэл авсан хүний тоо | Гадаадад ажиллаж амьдарч байгаа иргэдийн хуримтлал, хадгаламжийг эргэлтэд оруулах зэрэг шаардлагатай мэдээллийг web site-д байршуулна. |
| 10. | Ажилтны мэргэжлийн ур чадварыг харилцан зөвшөөрөх, магадлан итгэмжлэх, үнэмлэхжүүлэх болон хөдөлмөрлөх эрхийг харилцан зөвшөөрөх гэрээ, хэлэлцээрийг сонирхсон орнуудтай байгуулан хэрэгжүүлэх | 2006 оноос | Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам,Гадаад хэргийн яам | Шинээр байгуулсан гэрээ хэлэлцээрийн тоо | Бусад орны хөдөлмөрийн зах зээлийн эрэлт, хэрэгцээнд нийцсэн мэргэжилтэнг бэлтгэх, гадаад орнуудад ажиллуулах гэрээ, хэлэлцээрийг байгуулна. |
| Гурав. Бүртгэл, мэдээлэл, сургалт, судалгаа, сурталчилгааны ажлын талаар | | | | | |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 11. | Улсын хэмжээний хүн ам, өрхийн бүртгэл, хөдөлгөөний талаархи мэдээллийн нэгдсэн сүлжээг байгуулах | 2007 оноос | Үндэсний статистикийн газар, Иргэний бүртгэл, мэдээллийн улсын төв, Хил хамгаалах ерөнхий газар | Мэдээллийн сан болон сүлжээ байгуулагдсан байх | Өрхийн бүртгэлийн дэвтрийг өрхийн амьжиргааны түвшинтэй нь уялдуулан боловсронгуй болгох, мэдээллийг цуглуулах боловсруулах тусгай программыг ашиглан улсын хэмжээний сүлжээ байгуулна. |
| 12. | Гадаадад ажиллаж амьдарч байгаа иргэдийн бүртгэл мэдээллийг сайжруулж, мэдээллийн сан байгуулах | 2007-2008 онд | Үндэсний статистикийн газар, Гадаад хэргийн яам, Хил хамгаалах ерөнхий газар, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам | Мэдээллийн сан байгуулагдсан байх | Монгол Улсын иргэн гадаадад хувийн хэргээр зорчих, цагаачлах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хил, шалганы үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх замаар гадаадад ажиллаж амьдарч байгаа иргэдийн талаар мэдээллийн сан байгуулна. |
| 13. | Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн хуваарийн өөрчлөлтийн улмаас хүн ам зүйн үзүүлэлтэд гарах хандлага, өөрчлөлтийн талаар судалгаа хийж, бодлогын зөвлөмж боловсруулан хэрэгжүүлэх | 2006 оноос | Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Барилга, хот байгуулалтын яам, Бүх шатны Засаг дарга | Судалгаа хийсэн байх. Бодлогын зөвлөмж боловсруулсан байх | Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгжийн өөрчлөлттэй уялдуулан хүн ам зүйн үзүүлэлт, ялангуяа хүн амын шилжих хөдөлгөөнд гарч болзошгүй өөрчлөлт, хандлагын байдалд судалгаа хийнэ. |
| 14. | Хүн амын байршил, экосистемийн онцлог, цэвэр усны хангамжийн судалгаа хийж, хүн амыг оновчтой байршуулах талаар санал зөвлөмж боловсруулах | 2007 оноос | Байгаль орчны яам | Судалгааны тайлан, Бодлогын зөвлөмж | Хүн амын байршлыг усны хангамж, экосистемийн байдалтай уялдуулан судална. |
| 15. | Иргэдэд эрүүл аж төрөх есыг хэвшүүлэх, буруу зуршлаас сэргийлэх, зан үйлийг өөрчлөхөд чиглэсэн ухуулга, сурталчилгааг өргөжүүлэх чиглэлээр иргэний нийгмийн байгууллагатай хамтран ажиллах | 2006-2008 он | Эрүүл мэндийн яам, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Бүх шатны Засаг дарга | Гэрээ байгуулан ажиллаж буй байгууллагын тоо | Зөв хэрэглээ, эрдэм эрсдэл, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх талаархи сурталчилгааг өргөжүүлж, иргэдэд зориулсан хялбаршуулсан гарын авлага, материалыг бэлтгэн түгээнэ. |
| 16. | Хүн амын өвчлөл, нас баралтад нөлөөлж байгаа хүчин зүйлс, шалтгааны талаар эрдэм шинжилгээний ажлыг өргөжүүлэн, практикт нэвтрүүлэхэд дэмжлэг үзүүлэх | 2006 оноос | Эрүүл мэндийн яам, Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам | Хүн амын өвчлөл, нас баралт буурсан байх | Хүн амын өвчлөл, нас баралтын хандлагад гарч буй өөрчлөлттэй уялдуулан эрдэм шинжилгээний бүтээлийг дэмжинэ. |
| 17. | Иргэд, олон нийт, төрийн бус байгууллагын дэмжлэгтэйгээр уйгийн бичиг хөтлөх талаар мэдээлэл, сурталчилгааг өргөжүүлэх | 2006 оноос | Боловсрол, соёл, шинжлэх ухааны яам, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Угийн бичиг хөтлөх ажлыг зохицуулах зөвлөл | Угийн бичиг хөтлөлт нэмэгдсэн байх | Гэр бүлийг Угийн бичиг хөтөлж хэвшүүлж, ураг төрлийн гэрлэлт, цус ойртолтоос хамгаалах ажлыг зохион байгуулна. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 18. | Хууль эрх зүйн болон орон нутгийн онцлог, давуу тал зэрэг мэдээллээр шилжин суурьшигчдыг хангах, зөвлөгөө өгөх үйлчилгээг бий болгох, бүс, аймгийн web site-д энэ талаарх мэдээллийг байршуулах | 2007 оноос | Аймаг, нийслэлийн Засаг дарга нар, Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газар | Web site-д орж мэдээлэл авсан хүний тоо | Иргэдийг шилжин суурьших шийдвэр гаргахад дэмжлэг үзүүлэхэд чиглэсэн тухайн орон нутгийн онцлог, давуу тал, боломжийн талаарх мэдээллийг site-д байршуулна. |
| 19. | Хүн амын талаарх мэдээллийг хүйсээр ангилж, боловсронгуй болгох, мэдээлэл цуглуулах хугацаа, маягтад өөрчлөлт оруулах талаар судлан шийдвэрлэх | 2006-2008 онд | Үндэсний статистикийн газар, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам | Үндэсний статистикийн газраас гаргасан шийдвэр | Хүн амын асуудлаар цуглуулж буй бүх мэдээг хүйсээр ангилан мэдээллийн төрлийг олшруулах талаар Үндэсний статистикийн газартай хамтран ажиллана. |
| 20. | Хүн амын хөгжлийн асуудлаар мэдээлэл сурталчилгаа хийх мэргэшсэн сэтгүүлчдийн бaгийг байгуулан, тогтвортой ажиллах гэрээ байгуулах, үйл ажиллагааг нь урамшуулах, давтан сургалтад хамруулах талаар олон улсын байгууллагатай хамтран ажиллах | 2006 оноос | Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Хэвлэл мэдээллийн байгууллагууд | Гэрээ байгуулагдсан байх. Сэтгүүлчдийн баг тогтвортой үйл ажиллагаа явуулдаг болсон байх | Хэвлэл мэдээллийн ажилтнуудыг хүн амын хөгжлийн асуудлаар мэргэшүүлэн бүх түвшинд мэдээллийг оновчтойгоор хүргэх чадавхи бүхий багийг бүрдүүлэн, хамтран ажиллана. |
| 21. | Хүн ам, жендэрийн асуудлаар зайны сургалт, сурталчилгаа явуулах төв /студи/-ийг байгуулах | 2007 оноос | Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Хүн амын хөгжлийн асуудлаарх үндэсний хороо | Студи байгуулагдсан байх | Хүн амын асуудлаар видео хичээл бэлтгэх, нэвтрүүлэг хийх тоног төхөөрөмж, чадавхи бүхий төв /студи/-ийг байгуулна. |
| 22. | Хүн ам, жендэрийн асуудлаар сургалт зохион байгуулах, ухуулга сурталчилгаа явуулах мэргэшсэн багийг төв, орон нутгийн түвшинд зохион байгуулж, чадавхийг нь бэхжүүлэх сургалтыг тодорхой хугацаанд зохион байгуулж байх | 2006 оноос | Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Хүн амын хөгжлийн асуудлаарх үндэсний хороо | Сургалтын багаас төв, орон нутгийн түвшинд зохион байгуулсан сургалтын тоо | Орон нутгийн түвшид хүн амын хөгжлийн асуудлаар сургагч багшийг бэлтгэн, тэднийг тасралтгүй мэдээллээр хангаж, мэргэшүүлэн дэмжлэг үзүүлэх замаар баг байгуулан ажиллана. |
| 23. | Хүн ам, жендэр, хөгжлийн асуудлаар судалгаа, шинжилгээний ажил хийх чиг үүрэг бүхий институтийг байгуулах талаар холбогдох байгууллагатай зөвшилцөн шийдвэрлэх | 2006 оноос | Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Хүн амын хөгжлийн асуудлаарх үндэсний хороо | Институт байгуулагдсан байх | МУИС-ийн Хүн амын сургалт судалгааны төвийг өргөжүүлэх замаар эрдэм шинжилгээний ажил, судалгаа хийх чадавхи бүхий бүтцийг байгуулах асуудлыг судлан санал боловсруулна. |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | Дөрөв. Бүтэц зохион байгуулалтыг боловсронгуй болгох, хамтын ажиллагааны талаар | | | | |
| 24. | Хүн амын хөгжлийн асуудлыг хариуцан хэрэгжүүлэх чиг үүрэг бүхий бүтцийг байгуулах тухай асуудлыг судлан, санал боловсруулах | 2007 оноос | Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Хүн амын хөгжлийн асуудлаарх үндэсний хороо | Бүтцийн талаар санал боловсруулсан байх | Хүн амын хөгжлийн асуудлыг хариуцсан бүтцийг байгуулж болох санал, хувилбаруудыг боловсруулна. |
| 25. | Хүн амын хөгжил, жендэрийн тэгш байдлыг хангах асуудлаар НҮБ-ын төрөлжсөн болон бусад олон улсын байгууллага, иргэний нийгэм, нутгийн захиргааны байгууллагатай хамтран ажиллах, шинээр төсөл хөтөлбөрийг боловсруулан, санхүүжилтийг шийдвэрлэх | 2005 оноос | Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Гадаад хэргийн яам | Төсөл, хөтөлбөр батлагдан хэрэгжиж эхэлсэн байх | НҮБ-ын Хөгжлийн тусламжийн хүрээнд хүн амын хөгжлийн асуудлаар төсөл хөтөлбөрийг боловсруулан хэрэгжүүлэх, түүнд иргэний нийгэм, нутгийн захиргааны байгууллагын оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг явуулна. |
| 26. | НҮБ-ын төрөлжсөн байгууллагатай залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийг дэмжих асуудлаар хамтран ажиллах төсөл, хөтөлбөр боловсруулан ажиллах | 2007 оноос | Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Хүн амын хөгжлийн асуудлаарх үндэсний хороо | Санамж бичиг батлагдсан байх | НҮБ-ын төрөлжсөн байгууллагуудтай залуучууд, ахмад настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн талаар Санамж бичиг боловсруулан шийдвэрлүүлэх санаачилга гаргана. |
| 27. | Хүн амын хөгжил, жендэрийн тэгш байдлыг хангах асуудлаар хувийн хэвшил, буяны байгууллагаас гаргаж буй санал, санаачилгыг дэмжин урамшуулах таатай орчинг бүрдүүлэх | 2006 оноос | Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Хүн амын хөгжлийн асуудлаарх үндэсний хороо, Монголын худалдаа аж үйлдвэрийн танхим, Ажил олгогч эздийн холбоо | Хамтран ажилладаг байгууллагын тоо | Хувийн хэвшил, буяны байгууллагатай хамтран ажиллах санаачилгыг урамшуулах болзол гаргаж хэрэгжүүлнэ. |
| 28. | Хүн амын хөгжлийн асуудлаарх үндэсний хороо, орон нутгийн салбар зөвлөлийн чадавхийг бэхжүүлэх, үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэхэд шаардлагатай хөрөнгийн эх үүсвэрийг НҮБ-ын Хөгжлийн тусламжийн хүрээнд шийдвэрлэх | 2006 онд | Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Хүн амын хөгжлийн асуудлаарх үндэсний хороо | Хөрөнгийн хэмжээ | Хүн амын хөгжлийн асуудлаарх үндэсний хороо, орон нутгийн зөвлөлийн тогтвортой ажиллах санхүү, нөөцийг бүрдүүлнэ. |
| 29. | Хүн амын хөгжлийн асуудлаар сургалт, судалгаа, сурталчилгаа хийх чадавхи бүхий төрийн бус байгууллагатай хамтран ажиллах | 2006 оноос | Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн яам, Хүн амын хөгжлийн асуудлаарх үндэсний хороо | Гэрээ байгуулсан төрийн бус байгууллагын тоо | Сургалт, судалгаа, сурталчилгаа хийх чиглэлээр төрийн бус байгууллагатай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллана. |

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 1 дүгээр сарын 4–ний өдөр | Дугаар 4 | Улаанбаатар хот

### Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөр (2002-2010 он)-ийн зорилтыг хангах хоёр дахь шатны үйл ажиллагааны чиглэл батлах тухай

Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт хүүхэд, өсвөр үеийнхний хөгжил, хамгааллыг сайжруулах талаар дэвшүүлсэн зорилт, НҮБ-ын "Хүүхдэд ээлтэй дэлхий ертөнц" тунхаглалыг хэрэгжүүлэх зорилгоор Хүүхдийн эрхийг хамгаалах тухай хуулийн 10.3-ыг үндэслэн Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрийн хоёр дахь шатны үйл ажиллагааны чиглэлийг хавсралт ёсоор батлсугай.

2. Хөтөлбөрийн хоёр дахь шатны үйл ажиллагааны чиглэлд тусгагдсан ажлыг жил бүрийн Монгол Улсын эдийн засаг, нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэлд тусгаж ажиллахыг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрт тусгагдсан ажлыг зохион байгуулахад шаардагдах хөрөнгийг төсвийн ерөнхийлөн захирагч нарын төсвийн хүрээний дунд хугацааны мэдэгдэл, жил бүрийн төсвийн багцад болон гадаадын зээл, тусламжийн хөрөнгөөр санхүүжүүлэх төслийн жагсаалтад оруулах замаар хэрэгжүүлж ажиллахыг Монгол Улсын Шадар сайд Ч.Улаан, Сангийн сайд Н.Алтанхуяг, Хууль зүй, дотоод хэргийн сайд С.Батболд, Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайд П.Цагаан, Эрүүл мэндийн сайд Т.Ганди, Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Ц.Баярсайхан, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

4. Хүүхдийн хөгжил, хамгааллыг сайжруулах үндэсний хөтөлбөрийн зорилтыг хангах үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалтыг хэрэгжүүлэхэд шаардагдах зардлыг Монгол Улсын Шадар сайдын төсвийн багцад тусган санхүүжүүлж байхыг Сангийн сайд Н. Алтанхуягт, хөтөлбөрийн хэрэгжилтийн явц, үр дүнг жил бүр Хүүхдийн баярын өдрөөр нийт ард түмэнд мэдээлж байхыг Монгол Улсын Шадар сайд Ч.Улаанд даалгасугай.

5. Энэ тогтоол гарсантай холбогдуулан "Үндэсний хөтөлбөр батлах тухай" Монгол Улсын Засгийн газрын 2002 оны 12 дугаар сарын 4-ний өдрийн 245 дугаар тогтоолын 2, 3, 4 дүгээр зүйлийг хүчингүй болсонд тооцсугай.

МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Ц.ЭЛБЭГДОРЖ

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД Ч.УЛААН

*Засгийн газрын 2006 оны 4 дүгээр тогтоолын хавсралт*

## ХҮҮХДИЙН ХӨГЖИЛ, ХАМГААЛЛЫГ САЙЖРУУЛАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТЫГ ХАНГАХ ХОЁР ДАХЬ ШАТ (2005-2007)-НЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЧИГЛЭЛ

| Бүрэлдэхүүн хэсэг, хэрэгжүүлэх зорилт, үйл ажиллагааны төрөл | Хугацаа | Хариуцан боловсруулах, зохион байгуулах байгууллага | Санхүүжилтийн эх үүсвэр | |
|---|---|---|---|---|
| | | | Дотоод (сая.төг) | Гадаад (мян.US$) |
| **Бүрэлдэхүүн хэсэг I. Хүүхдэд ээлтэй эрх зүйн шинэтгэл** | | | | |
| **Зорилт 1. *Хүүхдийг дээдлэх зарчимд нийцүүлэн хүүхдийн эрхийг хамгаалахтай холбогдсон хууль тогтоомжийг шинэчлэн боловсруулна*** | | | | |
| 1. Хүүхдийн эрхийн тухай НҮБ-ын конвенци, ОУХБ-ын Ажил эрхлэх насны доод хязгаарын тухай 138, Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийн тухай 182 дугаар Конвенци болон Монгол Улсын нэгдэн орсон олон улсын гэрээний зарчимд тулгуурлан хүүхдийн эрхийг хамгаалах эрх зүйн орчны байдалд дүн шинжилгээ хийх | 2006-2007 | ХТҮГ, ХЗДХЯ, ГХЯ НХХЯ, ХЭҮК, ТББ | 15.0 | 20.0 |
| 2. "Хүүхдийн төлөө сан байгуулах, зарцуулах, хяналт тавих тухай", "Хүүхдийн байгууллагуудын эрх зүйн байдлын тухай", "Сургуулийн өмнөх боловсролын тухай" зэрэг хуулийн төсөл боловсруулах | 2006-2007 | ХТҮГ, БСШУЯ, ХЗДХЯ | 25.0 | 10.0 |
| 3.Монгол Улсын Хөдөлмөрийн тухай, Боловсролын багц хууль, Нийгмийн халамжийн тухай, Хүний эрхийн үндэсний комиссын тухай, Гэр бүлийн тухай, Хараа хяналтгүй хүүхдийг түр саатуулах тухай, Иргэний бүртгэлийн тухай, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай, Захиргааны хариуцлагын тухай, Эрүүгийн болон Эрүүгийн байцаан шийтгэх хууль зэрэгт хүүхдийн эрхийг хамгаалахтай холбоотой нэмэлт, өөрчлөлт оруулах тухай асуудлыг судалж, шийдвэрлүүлэх | 2005-2007 | НХХЯ, БСШУЯ, ХЗДХЯ ХЭҮК, ХТҮГ, ЦЕГ | 100.0 | 80.0 |
| 4. Олон улсын хүүхдийн Найрамдал төв, Хүүхэд асран хүмүүжүүлэх төв, Монголын хүүхдийн ордон, Хүүхдийн урлан бүтээх төв, Насанд хүрээгүй хүмүүсийг урьдчилан хорих болон засан хүмүүжүүлэх байгууллага зэрэг хүүхдэд үйлчилдэг байгууллагуудын үлгэрчилсэн дүрмийг боловсруулж батлах | 2006-2007 | Шадар сайдын ажлын алба, ХЗДХЯ, ХТҮГ | 1.0 | 30.0 |
| 5. Сэжигтэн, яллагдагчаар татагдсан хүүхдийн хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд оролцох хэрэг бүртгэгч, мөрдөн байцаагч, шүүгч, прокурор, өмгөөлөгч, нийгмийн ажилтныг хүүхдийн эрхийн асуудлаар мэргэшүүлэх сургалтыг бүсчлэн зохион байгуулж, хүүхдийн асуудлаар дагнасан шүүх байгуулах бэлтгэлийг эхлэх | 2006-2007 | ХЗДХЯ, ЦЕГ, УЕПГ, МӨХ, ХТҮГ, УДШ | 10.0 | 50.0 |
| 6. Хүүхдийн амь нас, эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх тоглоом наадмын жагсаалтыг батлах, хэрэгжилтийг хангах арга хэмжээ авах | 2006-2007 | НХХЯ, ЭМЯ, БСШУЯ ХТҮГ,аймаг,нийслэлийн Засаг дарга | 2.0 | 5.0 |
| 7. Сум, дүүрэгт "Насанд хүрээгүй хүмүүсийн хэрэг эрхлэх хороо" байгуулах асуудлыг судлан шийдвэрлэх | 2006-2007 | ХЗДХЯ, ХТҮГ, аймаг, нийслэлийн Засаг дарга | 2.0 | 10.0 |
| 8. Хүүхдийн оролцоо, төрөлхийн авьяас, давуу талыг дэмжих, хүүхдийн бүтээл, оюуны өмчийг хамгаалах, энэ талаар бодлогын баримт бичиг боловсруулж, баталгаажуулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх | 2006-2007 | ОӨГ, ХТҮГ, аймаг, нийслэлийн Засаг дарга | 3.0 | 10.0 |
| 9. Олон улсын гэрээнд үндэсний онцлог, хүүхдийн эрхийн асуудлаар судалгаа хийх, шаардлагатай бол түүнд нэгдэн орох асуудлыг судалж шийдвэрлүүлэх | 2006-2007 | ГХЯ, ХЗДХЯ, ХТҮГ,ТББ | 5.0 | 30.0 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 10. Хүүхдийг ялгаварлан гадуурхахаас сэргийлэх үндэсний стратеги боловсруулж хэрэгжүүлж эхлэх | 2006-2007 | НХХЯ, ХТҮГ, ХЭҮК | 2.0 | 50.0 |
| **Зорилт 2. *Хүүхдийн эрхийн хэрэгжилтийг хянана*** | | | | |
| 11. Хүүхдийн эрхийн байдлыг Хүүхдийн төлөө үндэсний Зөвлөлийн нээлттэй хурлаар жил бүр хэлэлцэж, "Монголын хүүхдийн аж байдал" тайланг олон нийтэд мэдээлдэг байх | 2006-2007 | ХТҮГ, ХЭҮК, аймаг, нийслэлийн Засаг дарга | 5.0 | 10.0 |
| 12. Хүүхдийн эрхийг хангах үндэсний тогтолцоог боловсронгуй болгох, "Хүүхдийн элч", "Хүүхдийн омбудсмен", "Хүүхдийн эрхийн ажилтан"-ы чиг үүрэг, хамаарлыг тодорхойлж, тэдгээрийн ажиллах эрх зүйн орчин, удирдлага, зохион байгуулалтын механизмыг бүрдүүлэх | 2006-2007 | ХТҮГ, БСШУЯ, ХЭҮК, аймаг, нийслэлийн Засаг дарга | 10.0 | 30.0 |
| 13. Бүх шатны Засаг даргын хүүхдийн эрхийг хамгаалах бүрэн эрхийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, дүнг тухайн шатны Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар хэлэлцүүлдэг байх | 2006-2007 | ХТҮГ, ТББ, аймаг, нийслэлийн Засаг дарга | 6.0 | 5.0 |
| 14. Хүний эрхийн чиглэлээр нэгдэн орсон олон улсын гэрээний хэрэгжилтэд хяналт тавих, хүүхдийн эрхийн асуудлаар зөвлөх олон нийт, иргэний нийгмийн механизм бүрдүүлэх | 2006-2007 | ХТҮГ, ГХЯ, ХЭҮК, аймаг, нийслэлийн Засаг дарга | 8.0 | 10.0 |
| 15. Хүүхдийн эрхийг хамгаалах төрийн чиг үүргийг хэрэгжүүлж байгаа байгууллагуудын стратегийг хэрэгжүүлэх суурьтай бүрдүүлэх зохион байгуулах, хүүхдийн аж байдлын мэдээлэл судалгааны сан бий болгох, байгууллага, иргэдийг мэдээллээр тогтмол хангах үйл ажиллагааг дэмжих | 2006-2007 | ХТҮГ, ҮСГ, Бүсийн зөвлөлүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга | 20.0 | 40.0 |
| 16. Насанд хүрээгүйчүүдийг түр саатуулах болон хорих ангийн үйл ажиллагааг НҮБ-ын дүрэм, журамд нийцүүлэн сайжруулж, төр, олон нийтийн хяналт тавьж ажиллах | 2006-2007 | ХТҮГ, УЕПГ, ХЭҮК, аймаг, нийслэлийн Засаг дарга, ТББ | 20.0 | 20.0 |
| 17. Хүний эрхийн үндэсний комисст хүүхдийн санал, гомдлыг хүлээн авах, судлах, шийдвэрлэх боломжийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах | 2006-2007 | ХЭҮК, ХТҮГ, аймаг, нийслэлийн Засаг дарга | 5.0 | 10.0 |
| 18. Хүүхдийн эрхийн байдалд олон нийтийн оролцоотой хяналт тавих шалгуур үзүүлэлтийг боловсруулах, хүүхдийн эрхийн зөрчилгүй гэр бүл, орон сууц, гудамж, хүүлийн этгээдийг урамшуулах замаар хүүхдэд ээлтэй орчинг бүрдүүлэх ажлыг төрөөс дэмжих | 2006-2007 | ХТҮЗ, ХТҮГ, аймаг, нийслэлийн Засаг дарга, ТББ, ХӨҮБ | 5.0 | 5.0 |
| 19. Улс, орон нутгийн төсөвт хүүхдийн асуудал хэрхэн тусгагдсан байдалд шинжилгээ хийх | 2006-2007 | ХТҮГ, СЯ, ТББ | 2.0 | 15.0 |
| **Бүрэлдэхүүн хэсгийн дүн** | | | **246.0** | **440.0** |
| ***Бүрэлдэхүүн хэсэг П. Хүүхдийн амьдралын эрүүл, аюулгүй орчин*** | | | | |
| ***Зорилт 3. Хүүхэд, өсвөр үеийнхний эрүүл мэндийг дэмжих, хамгаалах зохистой бүтэц, тогтолцоо бүрдүүлнэ*** | | | | |
| 20. Хүүхдийн эрүүл мэндийн чиглэлээр мэргэшсэн боловсон хүчний хэрэгцээ, байршлын талаар судалгаа хийж, тэднийг үе шаттайгаар бэлтгэх | 2005-2007 | ЭМЯ, ЭМШУИС, БСШУЯ | 20.0 | 20.0 |
| 21. Хүүхэд, өсвөр үеийнхний эмч, мэргэжилтнийг тогтвор суурьшилтай ажиллуулах, тэдний нийгмийн баталгааг хангах, ахуй нөхцөлийг сайжруулах арга хэмжээ авах | 2006-2007 | ЭМЯ, СЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга | 50.0 | 10.0 |
| 22. Хүүхдэд төрсөн цагаас нь иргэний үнэмлэх, нийгмийн хамгааллын дугаар олгох ажлын эхний үе шатны бэлтгэлийг хангаж, эрүүл мэндийн болон иргэний бүртгэл, мэдээллийн байгууллагын уялдаа холбоог сайжруулах | 2006-2007 | ЭМЯ, НХХЯ, ХЗДХЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга | 10.0 | 20.0 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| ***Зорилт 4. Хүүхэд, өсвөр үеийнхэнд ээлтэй эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлнэ*** | | | | |
| 23. Хүүхдийн эрүүл мэндийн тусламж, үйлчилгээг Мянганы хөгжлийн зорилтод нийцүүлэн боловсронгуй болгож, ураг нярайн болон 5 хүртэлх насны хүүхдийн өвчлөл, эндэгдлийг бууруулах "Хүүхдийн өвчний цогц менежмент (ХӨЦМ)", "Нярайн нэн шаардлагатай тусламж" хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх | 2005-2007 | ЭМЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга | 100.0 | 200.0 |
| 24. Дархлаажуулалтад шаардлагатай материал, хүйтэн хэлхээний тоног төхөөрөмжөөр сум, багийг бүрэн хангаж, хүүхдийг төрсний дараахь 24 цагийн дотор "В" гипатитын вакцинд хамруулах арга хэмжээг эрчимжүүлэн, тавт вакциныг үндсэний хэмжээнд хэрэглэж эхлэх | 2005-2007 | ЭМЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга | 500.0 | 200.0 |
| 25. Хүүхэд, өсвөр үеийнхний эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний стандартыг боловсруулж хэрэгжүүлэх | 2006-2007 | ЭМЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга | 150.0 | 50.0 |
| 26. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн эцэг, эх, асран хамгаалагчдыг нөхөн сэргээх эмчилгээний арга барилд сургах сургалт, сурталчилгаар өргөжүүлэх | 2006-2007 | ЭМЯ, НХХЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга | 100.0 | 60.0 |
| 27. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ авч чадахгүй байгаа эмзэг бүлгийн хүүхдийн эрүүл мэндийг дэмжих, хамгаалах, тэднийг дархлаажуулалтад хамруулах тусгайлсан арга хэмжээ авах | 2005-2007 | ЭМЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга | 200.0 | 600.0 |
| 28. Эрүүл мэндийн хэрэглээний талаар сургалт сурталчилгаар өргөжүүлж, шаардлагагүй тарилгаас татгалзах зан үйлийг бий болгох, сумдад эмийн эргэлтийн сан байгуулж, хүүхдийн өвчний нэн шаардлагатай 13 нэрийн эмээр тогтмол хангах арга хэмжээ авах | 2006-2007 | ЭМЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга | 100.0 | 50.0 |
| ***Зорилт 5. Хүүхэд, өсвөр үеийнхний зохистой хооллолтыг дэмжиж, аюулгүй хоол хүнсний хангамжийг нэмэгдүүлнэ*** | | | | |
| 29. Цэцэрлэг, сургуулийн хүүхдийн хоолны стандартыг боловсруулж хэрэгжүүлэх арга хэмжээ авах | 2006-2007 | БСШУЯ, СЯ, ЭМЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга | 60.0 | 10.0 |
| 30. Хүүхдийн хүнсний үйлдвэрлэл болон нийлүүлэлтэд тавих хяналтыг сайжруулах | 2005-2006 | ЭМЯ, ХХААЯ, ҮХЯ, УМХГ, УГЕГ, аж ахуйн нэгж байгууллагууд | 10.0 | 10.0 |
| 31. Мянганы хөгжлийн зорилтод нийцүүлэн нялхсын болон 5 хүртэл насны хүүхдийн хоол тэжээлийг сайжруулах арга хэмжээ авч, Эхийн сүү орлох бүтээгдэхүүний тухай хуулийг сурталчлах, хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулах | 2005-2007 | ЭМЯ, НЭМХ, аймаг, нийслэлийн Засаг дарга | 50.0 | 15.0 |
| 32. Эх, хүүхдийг бичил тэжээлийн дутагдлаас сэргийлэх стратегийг боловсруулан хэрэгжүүлэх | 2005-2007 | НХХЯ, ЭМЯ, ТББ | 50.0 | 100.0 |
| ***Зорилт 6. Хүүхэд, өсвөр үеийнхэн эсэн мэнд амьдрах, хөгжих орчин, нөхцөл бүрдүүлнэ*** | | | | |
| 33. Хүүхдийг ундны усаар хангах, хүүхдийн байгууллагын халуун усны болон бие засах газар, гар угаагуур зэргийн тоо, хүртээмжийг сайжруулах | 2005-2007 | ЭМЯ, БОЯ, БСШУЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга, ТББ | 150.0 | 200.0 |
| 34. Хүүхдэд зориулсан хувцас, тоглоом, хичээлийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн үйлдвэрлэл, нийлүүлэлтэд тавих хяналтыг сайжруулах | 2006-2007 | БСШУЯ, ҮХЯ, ЭМЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга, УМХГ, ТББ | 50.0 | 10.0 |
| 35. Хүрээлэн байгаа орчны бохирдол, хүний үйл ажиллагаанаас үүдсэн аюул осолд хүүхдийн эрүүл мэнд, амь нас хохирсон тохиолдолд буруутай этгээдэд нөхөн төлбөр, торгууль ногдуулах, түүний тодорхой хэсгийг "хүүхдийн өсөн хөгжих эрүүл аюулгүй орчин нөхцөл" бүрдүүлэх арга хэмжээнд зарцуулах эрх зүйн орчин бүрдүүлэх | 2006-2007 | БОЯ, БХБЯ, ЗТАЖЯ, СЯ, ЭМЯ, ХЗДХЯ, ХТҮГ | 50.0 | 5.0 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 36. Хүүхэд, өсвөр үеийнхний осол гэмтэл, нас баралтын шалтгаан, үр дагаврыг нарийвчлан гаргах механизмыг бий болгох | 2006- 2007 | НХХЯ, ЭМЯ, ЦЕГ, ХТҮГ, ИБМУТ | 5.0 | 20.0 |
| ***Зорилт 7. Хүүхэд, өсвөр үеийнхэнд эрүүл аж төрөх зан үйлийг төлөвшүүлнэ*** | | | | |
| 37. Хүүхэд, өсвөр үед эрүүл зан үйлийг төлөвшүүлэх албан болон албан бус сургалтын модуль боловсруулж хэрэгжүүлэх, гэр бүлд эрүүл мэндийн боловсрол олгох чиглэлээр зайны сургалт явуулах | 2006 оноос | ЭМЯ, БСШУЯ, НХХЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга, ТББ | 100.0 | 30.0 |
| 38. Хүүхэд, өсвөр үеийнхний эрүүл мэндийг хамгаалах, амьдралын эрүүл хэв маягт сургах, бухимдал тайлахад чиглэсэн зөвлөлгөө өгөх нийгмийн үйлчилгээний төрлийг олон улсын жишигт ойртуулах | 2005-2007 | ЭМЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга, ТББ | 20.0 | 100.0 |
| 39. Хүүхдэд бага наснаас нь гар угаах, амны хөндийг цэвэрлэх дадлыг хэвшүүлж, фтор дутлын эмгэгээс сэргийлэх арга хэмжээ авах | 2006-2007 | ЭМЯ, БСШУЯ, ТББ | 10.0 | 50.0 |
| 40. БЗХӨ, ДОХ, ХДХВ-ийн халдвартай тэмцэхэд эцэг эх, халамжлан хүмүүжүүлэгчид, нийгмийн ажилтны оролцоог нэмэгдүүлэх | 2006-2007 | ЭМЯ, БСШУЯ, НХХЯ, ХТҮГ, аймаг, нийслэлийн Засаг дарга, ТББ | 50.0 | 260.0 |
| 41. Хүүхэд, өсвөр үеийнхнийг чийрэгжүүлж, бие бялдраа хөгжүүлэх мэдлэг, чадвар, дадал эзэмшихэд нь чиглэсэн мэдээлэл, сурталчилгаа, сургалтын ажлыг өргөжүүлэх | 2006-2007 | ЭМЯ, БСШУЯ, НХХЯ, ХТҮГ, БТСУХ, аймаг, нийслэлийн Засаг дарга, ТББ | 100.0 | 250.0 |
| 42. Биеийн тамир, спортыг хүүхдийн эрүүл аж төрөх, чөлөөт цагийг зөв зохистой өнгөрүүлэх, авьяас чадвараа хөгжүүлэх арга хэрэгсэл болгон хамрах хүрээг өргөтгөх | 2006-2007 | ЭМЯ, БСШУЯ, БТСУХ, ХТҮГ,аймаг,нийслэлийн Засаг дарга, ТББ | 150.0 | 50.0 |
| 43. Хүүхдэд байгаль орчноо хайрлан хамгаалах уламжлалт ёс, зан заншлыг таниулах, экологийн боловсрол, хүмүүжил олгох асуудлыг ерөнхий боловсролын сургуулийн сургалтын хөтөлбөрт тусган хэрэгжүүлэх | 2005 оноос | БОЯ, ЭМЯ, БСШУЯ, ХТҮГ, аймаг, нийслэлийн Засаг дарга, ТББ | 100.0 | 100.0 |
| **Бүрэлдэхүүн хэсгийн дүн** | | | **2185.0** | **2420.0** |
| ***Бүрэлдэхүүн хэсэг Ш. Хүүхдийн чанартай боловсрол, төлөвшил*** | | | | |
| **Зорилт 8. *Сургуулийн өмнөх боловсролд хамрагдах хүүхдийн тоог нэмэгдүүлж, сургалтын агуулга, арга хэлбэрийг боловсронгуй болгоно*** | | | | |
| 44. Эмч, согог зүйч, багш, сэтгэл зүйч, мэргэжилтнүүдийн багийг аймаг бүрт ажиллуулж, зөвлөлгөө өгөх, сургалт явуулах, телевизийн нэвтрүүлгийг дохионы орчуулга, титертэй болгох арга хэмжээг авах | 2006 оноос | БСШУЯ, ЭМЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга | 10.0 | 200.0 |
| 45. Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний хамрах хүрээг тэлэх арга зүйг боловсруулах, багш бэлтгэх, цалин хөлсний эх үүсвэрийг шийдэх зэрэгт төрийн болон төрийн бус байгууллагуудын оролцоо дэмжлэгийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах | 2006 оноос | БСШУЯ, аймаг нийслэлийн Засаг дарга, ТББ | 100.0 | 20.0 |
| 46. Ээлжийн бүлэг, цагийн сургалтын хөтөлбөр модуль боловсруулж , эцэг эхийн арга зүйн сургалт, теле ба радиогийн зайны сургалт явуулах | 2006-2007 | БСШУЯ, аймаг нийслэлийн Засаг дарга, ТББ | 50.0 | 50.0 |
| 47. Бага насны хүүхдийн өсөлт хөгжлийн байдалд судалгаа хийж, хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд хамруулах арга хэмжээ авах | 2006 оноос | БСШУЯ, ЭМЯ, НХХЯ, аймаг, Нийслэлийн Засаг дарга | 10.0 | 50.0 |
| 48. "Сургуулийн өмнөх боловсролын сургалт, мэдээлэл, арга зүйн төв"-ийг түшиглэн бага насны хүүхдийн хөгжлийн асуудлаар арга зүйн зөвлөлгөө, дэмжлэг үзүүлэх ажлыг өргөжүүлэх | 2006 оноос | БСШУЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга, ТББ | 5.0 | 20.0 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 49. Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын төсөв, төлөвлөгөөг сургуулийн өмнөх насны бүх хүүхдийн тоотой уялдуулан боловсруулах зарчим баримтлах, зах хязгаар нутгийн болон малчдын хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд хамруулах хувьсах зардлыг төсөвт тусгах | 2006 оноос | БСШУЯ, СЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга | 5.0 | 100.0 |
| 50. Багш бэлтгэх, давтан сургах сургалтын хөтөлбөрийг боловсронгуй болгох, цэцэрлэгийн багш, туслах багшийн цалинг нэмэгдүүлэх арга хэмжээ авах | 2005-2007 | БСШУЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга | 5.0 | 200.0 |
| ***Зорилт 9. Суурь боловсролын үйлчилгээний чанар, хүртээмжийг дээшлүүлэн, хүүхдийг сурч боловсрох тэгш боломжоор хангах, тэдэнд амьдрах арга ухаан, мэргэжлийн чиг баримжаа олгох ажлыг өргөжүүлнэ*** | | | | |
| 51. ЕБС-ийн дотуур байрны багшийн ажлын байранд тавигдах шаардлага, хийх ажлын үлгэрчилсэн чиглэлийг боловсруулж мөрдүүлэх, тэдэнд зориулсан гарын авлага боловсруулан хүргэх, сургалт зохион байгуулах | 2006-2007 | БСШУЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга, ТББ | 20.0 | 10.0 |
| 52. ЕБС-ийн сурагчдад зориулсан үдийн цай, хоолны хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх | 2006-2007 | БСШУЯ, ЭМЯ, ХТҮГ | 100.0 | 300.0 |
| 53. Үндэсний цөөнхийн хүүхдүүд боловсрол эзэмших нөхцөл боломжоог дээшлүүлэх чиглэлээр дэмжлэг үзүүлэх | 2006-2007 | НХХЯ, БСШУЯ, ХЗДХЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга, ТББ | 20.0 | 20.0 |
| 54. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн нөхцөл байдлын орон нутгийн онцлогт тохирсон бодлогыг бүсчлэн хэрэгжүүлэх | 2006-2007 | БСШУЯ, СЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга, ТББ | 40.0 | 30.0 |
| 55. Хэл яриа, сонсголын бэрхшээлтэй хүүхдэд зориулсан "Дохионы хэлний толь бичиг" боловсруулан хэвлүүлэх, түгээх | 2006 оноос | БСШУЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга | 20.0 | 10.0 |
| 56. Хуульч, өмгөөлөгч, нийгмийн ажилтан, цагдаа, багш нар болон ЕБС-ийн сурагчдад анхан шатны дохионы хэлний сургалт зохион байгуулах | 2006-2007 | БСШУЯ, ЭМЯ, СЯ, НХХЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга, ТББ | 15.0 | 20.0 |
| 57. Багш бэлтгэдэг сургуулийн оюутнуудад дохионы хэл заах сургагч багшийн сургалт зохион байгуулах | 2006-2007 | БСШУЯ, НХХЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга | 5.0 | |
| 58. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг ердийн сургуульд сургах орчин бүрдүүлэх зорилгоор "Нөхөн сэргээх кабинет" байгуулж, ажиллуулахад сургуулиудад дэмжлэг үзүүлэх | 2006-2007 | БСШУЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга, ТББ | 50.0 | 50.0 |
| 59. Хүүхдийн эрхийн боловсрол хичээлийн сургалтын модуль боловсруулж, турших, багш бэлтгэх сургуулийн сургалтын хөтөлбөрт тусгах, "Хүүхдийн эрхийн боловсролын төв"-ийг байгуулж, үйл ажиллагааг нь эхлүүлэх | 2005 2007 | БСШУЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга, ХТҮГ, ТББ | 20.0 | 50.0 |
| 60. Хүүхдийг авто тээврийн ослоос урьдчилан сэргийлэхэд чиглэсэн арга хэмжээг олон нийтийн оролцоонд тулгуурлан явуулж, туршлагыг нь түгээн дэлгэрүүлэх | 2006-2007 | БСШУЯ, ХЗДХЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга, ТББ | 20.0 | 30.0 |
| 61. Хүнд нөхцөл дэх хүүхдийг сургууль завсардалтаас сэргийлэх, тогтвортой суралцуулахад чиглэсэн үйл ажиллагаар хүүхдэд ээлтэй сургуулийн шалгуур үзүүлэлтэд тусган хэрэгжилтэд хяналт тавьж ажиллах | 2006-2007 | БСШУЯ, НХХЯ, ХТҮГ, аймаг, нийслэлийн Засаг дарга, ТББ | 10.0 | 100.0 |
| 62. Ердийн ЕБС-ийн багш нарт хөгжлийн бэрхшээлтэй хүүхэдтэй ажиллах арга зүйн цуврал сургалт зохион байгуулах, гарын авлага боловсруулж хүргэх | 2006-2007 | БСШУЯ, ХТҮГ, аймаг, нийслэлийн Засаг дарга, ТББ, ХӨҮБ-ууд | 20.0 | 20.0 |
| 63. Сургууль завсардсан хүүхдэд боловсрол нөхөн олгох сургалтын зардлыг санхүүжүүлэх механизмыг оновчтой болгож, боловсрол нөхөн олгох сургалтын хүртээмж, чанарыг дээшлүүлэх | 2005 2007 | БСШУЯ, СЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга, ТББ | 400.0 | 100.0 |
| 64. Мэргэжлийн сургалт, үйлдвэрлэлийн төвийн болон мэргэжил эзэмшүүлэх урт, богино хугацааны сургалтыг өргөжүүлж, хүнд нөхцөлд байгаа хүүхдийн хамрах хүрээг нэмэгдүүлэх арга хэмжээ авах | 2005 2007 | БСШУЯ, НХХЯ, ҮХЯ, ХХААЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга | 100.0 | 50.0 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **Зорилт 10.** ***Сургууль, хичээлээс гадуурх сургалт, чөлөөт цагийг өнгөрүүлэх нөхцөлийг сайжруулж, хүүхдийн авьяас чадварыг хөгжүүлэн дэмжих таатай орчин бүрдүүлнэ*** | | | | |
| 65. Хүүхэд, өсвөр үеийнхний сурч, хөгжих үйл ажиллагааг дэмжих орчны эх тухтай байдлыг нэмэгдүүлэх, төв, суурин газрын чөлөөт цаг, соёлын төв, ордны засварт хөрөнгө оруулалт хийх | 2006-2007 | БСШУЯ, СЯ, ХТҮГ, аймаг, нийслэлийн Засаг дарга, ТББ | 1500.0 | 50.0 |
| 66. Сургууль, хичээлээс гадуур зохиогдох соёл, олон нийтийн ажлыг нэгдсэн төлөвлөгөөгөөр хэрэгжүүлж, хүүхэдтэй ажилласан багш-мэргэжилтэнд цагийн хөлс, урамшуулал олгох асуудлыг судалж шийдвэрлэх | 2005-2007 | БСШУЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга, ТББ | 5.0 | 20.0 |
| 67. Монголын түүх, соёлын дурсгалт газар нутагтай танилцах, ёс заншлаас суралцах, хөгжүүлэх үйл ажиллагааг дэмжих | 2006-2007 | БСШУЯ, БОЯ, ЗТАЖЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга, ТББ | 10.0 | 20.0 |
| 68. Хүүхэлдэйн театрын үйл ажиллагааг орон нутагт өргөжүүлэх арга хэмжээ авах | 2006-2007 | БСШУЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга | 20.0 | 10.0 |
| 69. Шинээр байгуулах орон сууцны хотхон, хороолold хүүхдийн чөлөөт цагийн танхим, биеийн тамир, тоглоомын талбайтай байх, цэцэрлэгт хүрээлэн, гудамж, талбайн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх | 2007 | БХБЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга | 10.0 | |
| 70. Аймгийн төв, нийслэлийн захын дүүрэг, гэр хороололд олон нийтийн санаачилгыг дэмжин урамшуулах замаар хүүхдийн тоглоомын талбайг нэмэгдүүлэх арга хэмжээ авах | 2006-2007 | БХБЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга | 20.0 | |
| 71. Хүн ам төвлөрсөн суурин газруудад чөлөөт цаг, соёлын төв шинээр байгуулах асуудлыг шийдвэрлэх | 2007 | БСШУЯ, СЯ, БХБЯ, ШСАА, аймаг, нийслэлийн Засаг дарга, Бүсийн зөвлөл | 100.0 | |
| 72. Урлагаар дамжуулан хүүхдэд гоо зүйн боловсрол олгох ажлыг өргөжүүлэх, соёл, урлагийн байгууллагыг түшиглэн хүүхдийн авьяасыг тэтгэх, хөгжүүлэх сургалтыг зохион байгуулах, үр дүнг олон нийтэд тайлагнах үйл ажиллагааг хэвшүүлэх | 2005-2007 | БСШУЯ, СЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга, ТББ | 100.0 | 50.0 |
| 73. Дотоодын аялал жуулчлалын маршрут гаргаж хүүхэд, өсвөр үеийнхний дунд эх орноо танилцах тойрон аяллыг хөгжүүлэх ажлыг дэмжин хэрэгжүүлэх | 2006-2007 | БСШУЯ, ЗТАЖЯ, БОЯ, ТББ | 100.0 | 10.0 |
| 74. "Морин хуур, уртын дуу" үндэсний хөтөлбөр хэрэгжүүлэхэд сургууль, цэцэрлэгийн үйл ажиллагааг идэвхжүүлэх | 2006-2007 | БСШУЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга, ТББ | 50.0 | 10.0 |
| 75. Олон улсын арга хэмжээнд шалгаран оролцох хүүхдэд дэмжлэг үзүүлэх зорилгоор "Хүүхдийн авьяас дэмжих сан"-г аймаг, дүүрэгт байгуулж ажиллуулах | 2006-2007 | БСШУЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга | 20.0 | |
| 76. Дуу, хөгжим, уран зураг, урлагийн бусад мэргэжлийн багш нарын сургалт-үзүүлэх ажлыг бүсчлэн зохион байгуулах, хүүхдэд гоо зүй, ёс суртахууны боловсрол олгоход төрийн болон төрийн бус мэргэжлийн байгууллага, уран бүтээлчид, эцэг эхчүүдийг татан оруулах арга хэлбэрийг боловсронгуй болгох | 2006-2007 | БСШУЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга, ОУХАТ, МХО, ХҮБТ, ТББ | 20.0 | |
| 77. Хүүхдийн амьдрах арга ухааны сургалтад ахмад настнуудын чадавхийг ашиглах "Төрийн сайн багш"-ийг сум, дүүрэг, аймаг, нийслэлийн хэмжээнд урамшуулдаг байх | 2005-2007 | ХТҮГ, аймаг, нийслэлийн Засаг дарга, Монголын ахмадын холбоо | 10.0 | |
| 78. Сургуулийн номын санг интернетэд холбож, мэдээллийн төв болгон өргөтгөн холбогдох зардлыг төсөвт тусгах асуудлыг дэс дараалан шийдвэрлүүлэх | 2005-2007 | БСШУЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга | 20.0 | 200.0 |
| 79. ЕБС-ийн биеийн тамир, дуу хөгжмийн хичээлийн сургалтын хэрэглэгдэхүүний хангамжийг нэмэгдүүлэх арга хэмжээ авах | 2006-2007 | БСШУЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга | 150.0 | 100.0 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 80.Сургуулийн номын сангийн үйлчилгээг хүүхдийн эрэлт хэрэгцээнд нийцсэн байдлаар зохион байгуулах, номын сангийн орчин нөхцөлийг сайжруулах | 2006-2007 | БСШУЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга, ТББ | 50.0 | 50.0 |
| Бүрэлдэхүүн хэсгийн дүн | | | **3210.0** | **1950.0** |
| **Бүрэлдэхүүн хэсэг IY. Гэр бүлд түшиглэсэн хүүхэд хамгаалал** | | | | |
| ***Зорилт 11. Гэр бүлийн таатай орчин бүрдүүлэх, нийгмийн үйлчилгээний хүрээг өргөжүүлэх замаар хүнд нөхцөлд байгаа хүүхдийн аж байдлыг сайжруулна*** | | | | |
| 81. Нийгмийн цогц, суурь үйлчилгээ хөтөлбөрийн өрхийг чадваржуулах стратегийг орон нутагт өргөжүүлэн 2007 оныг "Нийгмийн цогц-суурь үйлчилгээг дэмжих, Өрхийг чадваржуулах жил" болгон ажиллах | 2006-2007 | НХХЯ, ХТҮГ, аймаг нийслэлийн засаг дарга, ТББ | 250.0 | 150.0 |
| 82. Хүүхдийг зөв өсгөж хүмүүжүүлэх арга зүйд бие даан суралцах "Эцэг эх-бүх нийтийн сургалт"-ын хөтөлбөр, гарын авлага боловсруулж гаргах, түүнийг хэрэгжүүлэхэд мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлж ажиллах | 2006-2007 | ХТҮГ, НХХЯ, БСШУЯ, ЭМЯ, ТББ | 150.0 | 20.0 |
| 83. Ганц бие эцэг, эхтэй хүүхдүүд болон хүнд нөхцөлд амьдарч байгаа хүүхдийн гэр бүлийн гишүүдийг нийгмийн хамгааллын нэг цонхны үйлчилгээнд хамруулах | 2006-2007 | НХХЯ, БХБЯ, ТЭХЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга, ТББ | 300.0 | 100.0 |
| 84. Хүүхдийг гэр бүлийн орчноос тусгаарлахаас зайлсхийж, асрамж халамжийн газруудад байгаа хүүхдийн тоог бууруулах цогц арга хэмжээг зохион байгуулах, хүнд нөхцөлд байгаа хүүхдийг нийгэмшүүлэх, түр асрамжлах, өсгөн хүмүүжүүлэх санаачилга гаргасан гэр бүл, хувь хүмүүсийг урамшуулах төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх | 2006-2007 | НХХЯ, БСШУЯ, ХТҮГ, аймаг, нийслэлийн Засаг дарга, ТББ | 25.0 | 100.0 |
| 85. Гадаадын иргэд хүүхэд үрчлэх эрх зүйн орчныг боловсронгуй болгох | 2006-2007 | НХХЯ, ХЗДХЯ, ХТҮГ, ЦЕГ, ХЭҮК | 25.0 | 20.0 |
| 86. Хараа хяналтгүй хүүхдийн асуудлыг шийдвэрлэх, олон нийтийн сөрөг хандлага, ойлголтыг өөрчлөх, нийгмийн суурь үйлчилгээнд бүрэн хамруулах стратегийг боловсруулж хэрэгжүүлэх, олон нийтэд түшиглэсэн хүүхэд хамгаалах сайн дурын хөдөлгөөнийг дэмжих, урамшуулах | 2006-2007 | НХХЯ, БСШУЯ, ХТҮГ, аймаг, нийслэлийн Засаг дарга, ТББ | 200.0 | 100.0 |
| 87. Нэн ядуу гэр бүлийн шинээр төрсөн хүүхдэд төрсний гэрчилгээг үнэ төлбөргүй олгох асуудлыг судалж санал боловсруулах | 2006-2007 | НХХЯ, ХЗДХЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга | 2.0 | 10.0 |
| ***Зорилт 12. Хүүхдийг аливаа гэмт хэрэг, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, гэмт хэрэг үйлдсэн болон түүнд холбогдсон насанд хүрээгүй хүний эрхийг хамгаалах үйл ажиллагааг олон улсын жишигт хүргэнэ*** | | | | |
| 88. Гэмт хэрэг, хүчирхийлэл, зэрлэгээс хүүхдийг хамгаалах хөтөлбөр, төсөл боловсруулан хэрэгжүүлэх | 2006-2007 | НХХЯ, ТЭХЯ, БХБЯ, ЦЕГ, ХТҮГ, аймаг нийслэлийн Засаг дарга, ТББ | 100.0 | 100.0 |
| 89. Гэмт хэрэг, хүчирхийлэлд өртсөн гэр бүл, хүүхдэд сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх, хамгаалах байр ажиллуулах зэрэг хөтөлбөр, төсөл боловсруулж хэрэгжүүлэх | 2005-2007 | НХХЯ, ХТҮГ, ХХҮГ, ТББ, аймаг, нийслэлийн Засаг дарга | 100.0 | 100.0 |
| 90. Гэр бүл дэх хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаар олон нийтийн ойлголт хандлагыг өөрчлөх сургалт, сурталчилгааг нэгдсэн стратегийн дагуу хэрэгжүүлж, үр дүнг жил бүр олон нийтэд мэдээлж байх | 2006-2007 | НХХЯ, ХТҮГ, ЦЕГ, ТББ, аймаг, нийслэлийн Засаг дарга | 200.0 | 100.0 |
| 91. Хүүхдийн эсрэг хүчирхийллийн талаар үндэсний хэмжээний судалгаа хийж дүгнэлт гаргах | 2006- | НХХЯ, ХТҮГ, ХЭҮТ, ТББ | 10.0 | 30.0 |
| 92. Хүүхэд, насанд хүрээгүй хүмүүсийн мэдүүлэг авах олон улсын стандартад нийцсэн өрөөг бусдын төвүүдэд байгуулж, тохижуулах, хүүхдийн өмгөөлөгчийн ажлын хэлсийг төрөөс хариуцах асуудлыг боловсруулж шийдвэрлүүлэх | 2005-2007 | ХТҮГ, ЦЕГ, СЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга, ТББ | 10.0 | 50.0 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 93. Эрүүгийн хуулийн 69.2-ын дагуу сургалт, хүмүүжлийн байгууллагыг байгуулах асуудлыг шийдвэрлэх | 2006-2007 | ХЗДХЯ, ХТҮГ, нийслэлийн Засаг дарга | 100.0 | 200.0 |
| ***Зорилт 13. Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг устгахад чиглэсэн ажлыг эрчимтэй зохион байгуулна*** | | | | |
| 94. Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрт тооцсон 7 төрлийн хөдөлмөрийг эрхэлж байгаа хүүхдийг уг хөдөлмөрөөс хөндийрүүлэх, түүнээс урьдчилан сэргийлэх, хяналт тавих ажлыг өргөжүүлэх | 2005-2007 | НХХЯ, ҮХЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга, ХТҮГ, ээзд, үйлдвэрчний байгууллага, ТББ | 100.0 | 25.0 |
| 95. Насанд хүрээгүй хүн ажиллуулахыг хориглосон ажлын жагсаалтыг шинэчилж, олон нийтэд таниулах, хэрэгжүүлэх арга хэмжээ авах | 2006-2007 | НХХЯ, ҮХЯ, УМХГ, аймаг, нийслэлийн Засаг дарга, ХТҮГ, ТББ | 50.0 | 50.0 |
| 96. Хүүхдийн хөдөлмөр эрхлэлтийн байдалд үндэсний хэмжээний судалгаа явуулж, олон нийтийн хандлага, үйл ажиллагаагаа өөрчлөх сургалт, сурталчилгааг бусчлэн зохион байгуулах | 2006-2007 | НХХЯ, ҮХЯ, ҮСГ, аймаг, нийслэлийн Засаг дарга, ТББ | 60.0 | 200.0 |
| 97. Хүүхдийн хөдөлмөр бө түүнд хамааралтай (ядуурал, сургууль завсардалт, шилжилт хөдөлгөөн г.м) асуудлаар явуулах судалгаа, хяналт- шинжилгээ, үнэлгээний арга зүйг боловсронгуй болгох, сонгож авсан орон нутагт туршилтын төсөл хэрэгжүүлэх | 2006-2007 | НХХЯ, ҮХЯ, УМХГ, аймаг, нийслэлийн Засаг дарга, ХТҮГ, ээзд, үйлдвэрчний байгууллага, ТББ | 50.0 | 600.0 |
| 98. Ядуурлыг бууруулах, өрхийн амьжиргааны чадавхийг дээшлүүлэх төслийг сонгон шалгаруулах замаар хүнд нөхцөлд амьдардаг хүүхдэд гэр бүлээр нь дамжуулж халамж үйлчилгээ үзүүлэх, гэр бүлийн гишүүдийг мэргэжлийн сургалтад хамруулж, ажлын байраар хангах ажлыг зохион байгуулах | 2006-2007 | НХХЯ, БХБЯ, ҮХЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга, ТББ | 200.0 | 100.0 |
| 99. Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрүүдийг илрүүлэх, мэдээлэх, хяналт тавих үйл ажиллагаанд төр, олон нийтийн хяналт, мониторингийг сайжруулж, түүний үр дүнг жил бүрийн Хүүхдийн хөдөлмөрийн эсрэг олон улсын өдөр тайлагнаж хэвших | 2005-2007 | УМХГ, НХХЯ, ҮХЯ, ГХЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга, ээзд, үйлдвэрчний болон ТББ | 100.0 | 200.0 |
| 100. Уралдаан, спортын уламжлалт төрлүүдээр хичээллэж, уралдаан тэмцээнд оролцдог (хурдан морины уралдаан, уран нугаралт г.м) хүүхдийн эрүүл мэнд, хөдөлмөр хамгааллын аюулгүй байдалд үнэлгээ хийж, эрх зүйн орчныг боловсронгуй болгох, хүүхдийн аюулгүй байдлыг хангах олон нийтийн ухамсрыг дээшлүүлэх арга хэмжээ авах | 2005-2007 | Аймаг, нийслэлийн Засаг дарга, ХТҮГ, БТСҮТ, Баяр наадмын салбар хороо, ТББ | 50.0 | 40.0 |
| ***Зорилт 14. Хүүхдийг байгалийн гамшиг, ган, зуд, үер ус, гал түймэр, халдварт өвчний тархалтаас хамгаалах үндэсний чадавхийг бэхжүүлнэ*** | | | | |
| 101.Байгалийн гамшиг, нийтийг хамарсан осол, халдварт өвчнөөс хүүхдийг урьдчилан сэргийлэх, аврах хамгаалах, бэлэн байдлыг хангах асуудлаар гэрээ байгуулж ажиллах | 2005-2007 | ОБЕГ, ХТҮГ, аймаг, нийслэлийн Засаг дарга, ТББ | 250.0 | 200.0 |
| 102.Гамшигт нэрвэгдсэн хүүхдэд тусламж үзүүлэх зорилго бүхий сайн дурын идэвхтэн, мэргэшсэн албадыг бэлтгэх, өсвөр үеийнхний бүлгийг дэмжих сургалт, үйл ажиллагаа зохион байгуулж, тогтмолжуулах | 2006-2007 | ОБЕГ, НХХЯ, ЭМЯ, БСШУЯ, БОЯ, ХТҮГ, аймаг, нийслэлийн Засаг дарга, ТББ | 100.0 | 50.0 |
| **Бүрэлдэхүүн хэсгийн дүн** | | | **2432.0** | **2545.0** |
| ***Бүрэлдэхүүн хэсэг V. Хүүхэд, өсвөр үеийнхний оролцоо, мэдээллийн хүртээмж*** | | | | |
| ***Зорилт 15. Хүүхдийн оролцоо, өөрийн удирдлагын байгууллагын гүйцэтгэх үүргийг нэмэгдүүлэхэд чиглэсэн олон нийтийн хамтын үйл ажиллагааг хөгжүүлнэ*** | | | | |
| 103. Хүүхдийн оролцоог дэмжих бодлогын баримт бичгийг боловсруулан баталгаажуулж, хүүхдийн өөрийн удирдлагын байгууллагыг дэмжих арга зүйг ээзмшүүлэх бусийн сургалтыг багш, нийгмийн ажилтан, арга зүйчдийн дунд зохион байгуулж, үр дүнг хянах | 2006-2007 | ХТҮГ, БСШУЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга, ТББ | 70.0 | 100.0 |

| | | | | |
|---|---|---|---|---|
| 104. Нийгэм, соёлын амьдралын бүх хүрээнд хүүхэд, өсвөр үеийнхний оролцоог сургалтжуулах, хүндэтгэн хэрэгжүүлэх гэр бүл, олон нийтэд зориулсан сургалт, сурталчилгаар өргөжүүлж, тогтмолжуулах | 2005-2007 | ХТҮГ, БСШУЯ, НХХЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга, ТББ | 50.0 | 10.0 |
| 105. Хүүхэд, өсвөр үеийнхний хөгжил, оролцоог ялангуяа хүнд нөхцөлд амьдардаг хүүхдийн үзэл бодлыг нээх боломжийг дэмжих асуудлаар хамтран ажиллах | 2006-2007 | БСШУЯ, НХХЯ, ХТҮГ, аймаг, нийслэлийн Засаг дарга, ТББ | 15.0 | 50.0 |
| ***Зорилт 16. Хүүхэд, өсвөр үеийнхний эрхээ эдлэх, үзэл бодлоо чөлөөтэй илэрхийлэх чадварыг хөгжүүлнэ*** | | | | |
| 106. Гэр бүл, сургуулийн түвшинд хүүхдийн үзэл бодлыг хүндэтгэх олон нийтийн хандлагыг дээшлүүлэх, хүүхдэд чиглэсэн амьдрах ухааны сургалт, сурталчилгааг өргөжүүлэх | 2005-2007 | ХТҮГ, яамд, аймаг, нийслэлийн Засаг дарга, ТББ | 10.0 | 15.0 |
| 107. Хүүхэд, өсвөр үеийнхний өөртөө зориулсан ажил, үйлчилгээнд үнэлгээ, дүгнэлт өгөх чадварыг хүүхдийн өөрийн удирдлагын байгууллагаар дамжуулан хөгжүүлэх ажлыг зохион байгуулах | 2006-2007 | ХТҮГ, БСШУЯ, аймаг, нийслэлийн Засаг дарга, ТББ | 5.0 | 5.0 |
| 108. Хүүхдийн үндэсний чуулган, орон нутгийн хүүхдийн чуулганыг тогтмол хугацаанд зохион байгуулах, зардлыг улс, орон нутгийн төсөв болон бусад эх үүсвэрт тусган шийдвэрлэж байх | 2005-2007 | ХТҮГ, аймаг, нийслэлийн Засаг дарга, ТББ | 50.0 | 20.0 |
| ***Зорилт.17 Хүүхэд, өсвөр үеийнхэн мэдээллийг эрж хайх, сонгох, боловсруулах, ашиглах, түгээх нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн төр, олон нийтийн дэмжлэгийг өргөжүүлнэ*** | | | | |
| 109. Хүүхдэд чиглэсэн мэдээллийн төрөл, сувгийг дэмжих, мэдээллийн сөрөг нөлөөнөөс хүүхдийг хамгаалах, урьдчилан сэргийлэх арга хэмжээг боловсруулж хэрэгжүүлэх | 2006-2007 | БСШУЯ, ОНРТ, МХХТГ, ХТҮГ, МТҮХ, ТББ | 10.0 | 20.0 |
| 110. Хүүхдийн асуудлаар мэргэшсэн сэтгүүлч, хэвлэл мэдээллийн ажилтан бэлтгэх, давтан сургах, мэргэшүүлэх, урамшуулах | 2005-2007 | ТББ, аймаг, нийслэлийн Засаг дарга | 10.0 | 30.0 |
| 111. Хүүхэд, өсвөр үеийнхэнд хэвлэл мэдээллийн хэрэгсэл ашиглан үзэл бодлоо илэрхийлэх чадварт сургах сургалтын модуль боловсруулан хэрэгжүүлэх | 2006-2007 | ХТҮГ, БСШУЯ, аймаг нийслэлийн Засаг дарга, ТББ | 5.0 | 50.0 |
| **Бүрэлдэхүүн хэсгийн дүн** | | | **225.0** | **300.0** |
| ***Бүрэлдэхүүн хэсэг YI. Хүүхдийн төлөө байгууллагын үндэсний чадавхи бүрдүүлэлт*** | | | | |
| ***Зорилт 18. Хүүхдийн төлөө байгууллагын үндэсний чадавхийг шинэ зууны шаардлагад нийцүүлэн сайжруулна*** | | | | |
| 112. Хүүхдийн төлөө анхан, дунд шатны төрийн байгууллагын чадавхийг бэхжүүлэх үйл ажиллагаар үе шаттай хэрэгжүүлэх | 2006-2007 | ХТҮГ, яамд, ХТҮЗ, аймаг, нийслэлийн Засаг дарга, ТББ | 10.0 | 80.0 |
| 113. Иргэд, олон нийт, мэргэжилтнүүдэд хүүхдийн эрхийн мэдлэг, мэдээлэл олгох ажлыг эрчимжүүлж, бэлтгэгдсэн сургагчдыг хүүхдийн эрхийн асуудлаар төрөлжсөн сургалтад хамруулан, хүний эрхийн боловсрол олгох ажлыг тасралтгүй зохион байгуулах | 2006-2007 | ХТҮГ, яамд, аймаг, нийслэлийн Засаг дарга, ТББ | 10.0 | 50.0 |
| 114. Цагдаа, Прокурор, Шүүх, Өмгөөллийн байгууллагад хүүхэд, насанд хүрээгүйчүүдийн асуудлыг дагнан хариуцах нэгж, мэргэшсэн ажилтан ажиллуулах асуудлыг судалж, үе шаттай шийдвэрлэх | 2006-2007 | ХЗДХЯ, МӨХ, ХТҮЗ, аймаг, нийслэлийн Засаг дарга, ТББ | 50.0 | 40.0 |
| 115. Багш, хүмүүжүүлэгч, нийгмийн ажилтан бэлтгэдэг их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт хүүхдийн эрх, нийгэм, сэтгэл зүй, сурган хүмүүжүүлэх ухааны хичээлийн цагийг нэмэгдүүлэх, агуулга, арга зүйг боловсронгуй болгох ажлыг эрчимжүүлэх | 2006-2007 | БСШУЯ, ХТҮГ, ХЭҮК, ТББ | 20.0 | 20.0 |
| **Бүрэлдэхүүн хэсгийн дүн** | | | **90.0** | **190.0** |
| **НИЙТ ДҮН** | | | **8388.0** | **7845.0** |

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 1 дүгээр сарын 4-ний өдөр | Дугаар 5 | Улаанбаатар хот

### Хөтөлбөрийг хэрэгжүүлэх II шатны үйл ажиллагааны үндсэн чиглэл батлах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

1. Жендэрийн тэгш байдлыг хангах Үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх II шатны үйл ажиллагааны үндсэн чиглэлийг хавсралт ёсоор батлагсугай.

2. Үндсэн чиглэлийг хэрэгжүүлэх ажлыг улсын хэмжээнд зохион байгуулж ажиллахыг Нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн сайд Ц.Баярсайхан, хөтөлбөрийг өөрийн эрхлэх асуудлын хүрээ, орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлэхийг Засгийн газрын гишүүд, аймаг, нийслэлийн Засаг дарга нарт үүрэг болгосугай.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД Ц.ЭЛБЭГДОРЖ**

**НИЙГМИЙН ХАМГААЛАЛ, ХӨДӨЛМӨРИЙН САЙД Ц.БАЯРСАЙХАН**

***Засгийн газрын 2006 оны 5 дугаар тогтоолын хавсралт***

### ЖЕНДЭРИЙН ТЭГШ БАЙДЛЫГ ХАНГАХ ҮНДЭСНИЙ ХӨТӨЛБӨРИЙН ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ХОЁРДУГААР ШАТ /2005-2008 ОН/-НЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮНДСЭН ЧИГЛЭЛ

| № | Үйл ажиллагааны чиглэл | Хэрэгжүүлэх хугацаа | Хариуцах байгууллага | Санхүүжилтийн эх үүсвэр: Дотоод (сая.төг) | Санхүүжилтийн эх үүсвэр: Гадаад (мян. ам.дол) | Гарах үр дүн | Эрсдэл, гадны нөлөөлөл |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **Нэг. Гэр бүлийн хөгжил дэх жендэрийн тэгш байдал** | | | | | | |
| 1 | Суурь, бүрэн дунд, дээд боловсролын түвшин дэх хүйсийн тэнцвэргүй байдлын шалтгаан, үр дагаврыг багасгахад чиглэсэн төлөвлөгөө, төсөл боловсруулж, хэрэгжүүлэх | 2006 оноос | БСШУЯ, эрдэм шинжилгээ судалгааны байгууллагууд | 5.0 | 8.0 | Суурь, бүрэн дунд, дээд боловсролд хамрагдагдын хүйсийн зөрөө буурна | Гэр бүл, эрэгтэйчүүдийн дэмжлэг |
| 2 | Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуультай холбогдох хууль тогтоомжийг нийцүүлэх асуудлыг судалж шийдвэрлүүлэх | 2006 оноос | ХЗДХЯ, НХХЯ | - | - | Холбогдох хууль тогтоомж боловсронгуй болно | Шийдвэр гаргагчдын дэмжлэг |
| 3 | Гэр бүлийн хүчирхийлэл нь бусад зөрчил, гэмт хэргийн адил хуулийн хариуцлага хүлээдэг болох талаар ойлголт өгөх сургалтыг олон нийтэд зориулан зохион байгуулах | 2006 оноос | ХЗДХЯ, НХХЯ | 6.0 | 8.0 | Хүчирхийлэл үйлдэгчийн зан үйлд нөлөөлөх сургалтын хөтөлбөр батлагдана | Шийдвэр гаргагчдын дэмжлэг, хүний нөөцийн хомсдол |
| 4 | Гэр бүлийн гишүүдийн эрх, үүрэг, хариуцлага, жендэрийн тухай болон нөхөн үржихүйн эрүүл мэнд, ДОХ/ХДХВ, БЗХӨ болон бусад халдварт өвчин, хорт зуршилтай тэмцэх, тадгээрээс урьдчилан сэргийлэхэд эрэгтэйчүүдийн оролцоог нэмэгдүүлэх талаар сургалт, сурталчилгааны ажлыг сайжруулах, энэ асуудлыг батлан хамгаалах, хилийн цэрэг, цагдаагийн алба хаагчдыг бэлтгэдэг их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт тусган хэрэгжүүлэх | Жил бүр | ЭМЯ, БХЯ, ХЗДХЯ, НХХЯ, аймгийн ЗДТГ | 7.0 | Олон улсын хандивлагч байгууллагын шугамаар хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх | Сургалт, сурталчилгааны ажил сайжирч, эрэгтэйчүүдийн оролцоо нэмэгдэнэ | Холбогдох байгууллагын идэвх санаачилга, хэрэгнэ |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| 5 | Гэр бүл, жендэр судлалыг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх | Жил бүр | БСШУЯ, ШУА | 3.0 | 8.0 | Гэр бүл, жендэрийн асуудлаар судалгаа шинжилгээний бүтээлийн тоо нэмэгдэж | Хөрөнгө, гэр бүлийн асуудлаар үйл ажиллагаа явуулж буй байгууллагуудын оролцоо, санаачилга |
| **Хоёр. Эдийн засгийн харилцаан дахь жендэрийн тэгш байдал** | | | | | | | |
| 6 | Бодлого төлөвлөлтөд жендэрийн асуудлыг тусгах чиглэлээр төрийн албан хаагчдын чадавхийг нэмэгдүүлэх сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах | 2006 оноос | СЯ, Төрийн албаны зөвлөл | 3.0 | 5.0 | Бодлого боловсруулагч, шийдвэр гаргагчдын жендэрийн мэдрэмжтэй төлөвлөх чадавхи нэмэгдэнэ | Зорилтот бүлгийн оролцоо |
| 7 | Өрх гэрийн хөлсгүй хөдөлмөрийн үнэлэмжийг дээшлүүлэх асуудлаар мэдээлэл, сургалт, сурталчилгааны ажлыг зохион байгуулах | 2006 оноос | ҮСГ, СЯ, НХХЯ | - | 6.0 | Өрх гэрийн хөлсгүй хөдөлмөрийг үндэсний тооцооны системд тусгах санал боловсрогдоно | Хөрөнгө, олон нийтийн дундах хэвшмэл үзэл |
| 8 | Төрөөс албан бус хөдөлмөр эрхлэлтийн талаар баримтлах бодлогын баримт бичигт жендэрийн чиг хандлагыг тусгах ажлыг зохион байгуулах | 2005 оноос | НХХЯ | - | - | Албан бус хөдөлмөр эрхлэлтийн бодлого, хөтөлбөр жендэрийн мэдрэмжтэй болно | Бодлого боловсруулагчдын жендэрийн талаархи мэдлэг |
| 9 | Манай улсын нэгдэн орсон Хөдөлмөр эрхлэлтэд ялгаварлан гадуурхахгүй байх тухай 111 дүгээр конвенцид үндэсний хууль тогтоомжийг нийцүүлэх | 2008 | ХЗДХЯ, НХХЯ, Улсын мэргэжлийн хяналтын газар | - | ОУХБ, Хүний эрхийн асуудлаар үйл ажиллагаа явуулдаг олон улсын байгууллагад хандана | Холбогдох хууль боловсронгуй болно | Шийдвэр гаргагчдын дэмжлэг, олон нийт, ажилтагчдын эрхээ хамгаалах талаархи ойлголт, мэдлэг |
| **Гурав. Хөдөөгийн хөгжил дэх жендэрийн тэгш байдал** | | | | | | | |
| 10 | Хүүхдийн сургууль завсардалтын хор уршгийг эцэг, эх, асран хамгаалагчдад ойлгуулахын зэрэгцээ охид, хөвгүүдэд хүйсээр болон амьдралын түвшингээр ялгаварлахгүй, адил тэгш хандах хандлагыг багш, сурган хүмүүжүүлэгчид, хүүхэд, эцэг, эхчүүдэд төлөвшүүлэх ажлыг зохион байгуулах | Жил бүр | БСШУЯ, НХХЯ | 3.0 | 9.0 | Сургууль завсардалт буурна | Хөрөнгө, дэмжлэг |
| 11 | Хүн амын нас баралтын шалтгаанд жендэрийн мэдрэмжтэй судалгаа хийж, гарсан дүнгээр үндэслэн санал боловсруулах | 2006 оноос | ЭМЯ, НХХЯ | - | 8.0 | Нас баралт, өвчлөлийг бууруулах тодорхой санал, зөвлөмж боловсрогдсон байна | Хөрөнгө, дэмжлэг, судалгааны аргачлал |
| 12 | Аймаг, сумын төв, хилийн бүс нутгийн иргэдийн дунд өрхийн аж ахуй, хоршоолол эрхлэх боломжийг судалж, бизнес эрхлэх сургалт зохион байгуулах | 2006 оноос | Хөдөлмөр, халамж үйлчилгээний газар, Өрхийн амьжиргааг дэмжих хөтөлбөрийн газар | Тогтвортой амьжиргааг дэмжих төсөл, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих сангийн санхүүжилтээр хэрэгжүүлнэ | | Сургалтад хамрагдсан орлого багатай иргэдийн өрхийн аж ахуй, бизнес эрхлэх ур чадвар нэмэгдсэн байна | Мэдээллийн хүртээмж, зорилтот бүлгээ зөв тодорхойлж, хамруулсан байх |

| | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|
| | **Дөрөв. Шийдвэр гаргах түвшин дэх жендэрийн тэгш байдал** | | | | | | |
| 13 | Сонгогчдын жендерийн мэдрэмжийг сайжруулах зорилгоор жендэрийн тэгш байдлыг хангахад чиглэгдсэн сургалтыг орон нутгийн удирдлага, ТББ, олон нийтийн дунд үе шатгайгаар зохион байгуулах | 2007-2008 | ЖТБҮХороо, аймаг, нийслэлийн ЗДТГ, улс төрийн намууд. | Орон нутгийн байгууллага, эмэгтэйчүүдийн үүсгэл, санаачилгаар олон улсын байгууллага, ТББ-уудын дэмжлэгтэй жижиг төслүүд хэрэгжүүлнэ | | Сонгогчдын жендэрийн мэдрэмж сайжирна | Орон нутгийн байгууллагуудын идэвх, оролцоо, хандивлагчдын дэмжлэг |
| 14 | Залуучууд, эмэгтэйчүүдийг удирдлагад бэлтгэх сургалтыг зохион байгуулах | 2007 оноос | ЖТБҮХороо, Парламентад суудалтай улс төрийн намын дэргэдэх эмэгтэйчүүдийн байгууллага | 3.0 | - | Улс төрийн намын бодлого жендэрийн мэдрэмжтэй болж, залуу гишүүд, дэмжигч эмэгтэйчүүдийн оролцоо нэмэгдсэн байна | Улс төрийн намын гишүүд, дэмжигчдийн сонирхол, идэвх оролцоо, намын зүгээс тэднийг дэмжих дэмжлэг |
| 15 | Бодлого, хөтөлбөр, шийдвэрт иргэдийн санал, хүсэлтийг тусгахад чиглэсэн сургалтыг олон нийт, хэвлэл мэдээллийн ажилтнуудын дунд зохион байгуулах | 2007 оноос | НХХЯ, БСШУЯ, Олон нийтийн радио, телевиз | - | 5.0 | Олон нийтийн оролцоо сайжирсан байна | Хөрөнгө, хэвлэл мэдээллийн байгууллагуудын оролцоо |
| | **Тав. Жендэрийн асуудлаархи үндэсний тогтолцоо ба иргэний нийгмийн оролцоо** | | | | | | |
| 16 | Жендэрийн тэгш байдлыг хангах Үндэсний хөтөлбөрийн хяналт-шинжилгээ, үнэлгээний шалгуур үзүүлэлтийг Мянганы хөгжлийн зорилт, Эдийн засгийн өсөлтийг дэмжих, ядуурлыг бууруулах стратегийн зорилт, үр дүнтэй уялдуулан боловсронгуй болгох | 2006 оноос | НХХЯ,СЯ, ҮСГ | 3.0 | 5.0 | Жендэрийн тэгш байдлыг хангах Үндэсний хөтөлбөр боловсронгуй болно | Засгийн газрын дэмжлэг |
| 17 | Жендэрийн асуудлаар мэдээллийн сүлжээ байгуулж, жендэрийн талаархи зөв ойлголтыг олон нийтэд төлөвшүүлэх, мэдээллийг хүртээмжтэй болгох | 2006 оноос | ЖТБҮХороо, Мэдээлэл, харилцаа холбоо, технологийн газар, ҮСГ | - | 7.0 | Жендэрийн асуудлаар мэдээллийн хүртээмж сайжирна | Хөрөнгө, нөөц |
| 18 | Төрөөс иргэний нийгмийн байгууллагатай сайн засаглал, жендэрийн асуудлаархи түншлэлийг хөгжүүлж, харилцан мэдээлэл солилцож хамтран ажиллах, эрэгтэйчүүдийн эрх ашгийг хамгаалах чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа төрийн бус байгууллагад дэмжлэг үзүүлэх | жил бүр | НХХЯ | 20.0 | - | Жендэрийн асуудлаар төр, иргэний нийгмийн хамтын ажиллагаа сайжирна | Иргэний нийгмийн байгууллагуудын санаачилга, мэдээлэл тогтмол солилцох боломж |
| | **Дүн** | | | **53.0** | **69.0** | | |

## МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ТОГТООЛ

2006 оны 1 дүгээр сарын 18-ны өдөр | Дугаар 9 | Улаанбаатар хот

### Журамд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газраас ТОГТООХ нь:

Засгийн газрын 2001 оны 150 дугаар тогтоолоор батлагдсан "Улсын сайн малчин шалгаруулах журам"-ын 2 дугаар заалтын "... 25 хүртэлх ... " гэснийг "... 30 хүртэлх ..." гэж өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ Ц.ЭЛБЭГДОРЖ**

**ХҮНС, ХӨДӨӨ АЖ АХУЙН САЙДЫН ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭГЧ Д.ТЭРБИШДАГВА**

## МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2006 оны 2 дугаар сарын 22-ны өдөр | Дугаар 2/02 | Улаанбаатар хот

### Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 209 дүгээр тогтоолын 3 дахь заалт Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх тухай маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхим 15.00 цаг

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн дарга Ж.Бямбадорж даргалж, гишүүн Л.Рэнчин, П.Очирбат, Ч.Дашням /илтгэгч/, Ц.Сарантуяа нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн даргаар Д.Нарантуяаг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд өргөдөл гаргагч иргэн Д.Оюун, Я.Эрдэнэ тэдгээрийн итгэмжлэлээр өмгөөлөгч Ц.Цэрэнжээ, Н.Цогт, М.Баяраа мөн Засгийн газрын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ц.Содномпил нар оролцлоо.

***Нэг. Нийслэлийн Баянзүрх дүүргийн 3 дугаар хорооны оршин суугч, иргэн Д.Оюун, мөн дүүргийн 11 дүгээр хорооны оршин суугч, иргэн Я.Эрдэнэ нар Үндсэн хуулийн цэцэд 2005 оны 11 дүгээр сарын 1-ний өдөр ирүүлсэн өргөдөлдөө:***

"Монгол Улсын Эрүүл мэндийн сайдын 2001 оны 76 дугаар тушаалын дагуу Эрүүл мэндийн үйлчилгээний II төвийг байгуулж, эмнэлгийн үйлчилгээг нэг дороос чирэгдэлгүй, шуурхай зохион байгуулах үүднээс хувийн хэвшлийн нэр бүхий 15 эмнэлэг хариуцан, ажлын байрыг яамнаас түрээсийн гэрээний үндсэн дээр эзэмшүүлж, ашиглуулахаар зохицуулж, үйл ажиллагаагаа явуулах болсноор 5 дахь жилийнхээ нүүрийг үзэж 180000 гаруй байнгын үйлчлүүлэгчтэй болж, үйл ажиллагаа нь өргөжиж байна.

Нэр бүхий 15 эмнэлгийн байгууллага 5 жилийн хугацаанд байрны ашиглалтыг сайжруулж, засвар үйлчилгээг хариуцан, төлбөрийг цаг хугацаанд нь тогтмол төлж ирсэн. Уушигны мэс засал, эмэгтэйчүүд, дотор, мэдрэл, уламжлалт эмнэлэг, мэс засал, судас шамбарам зэрэг нарийн мэргэшсэн чиглэлээр эмнэлгийн 100 гаруй ажилтан /үүнээс 50 гаруй хувь нь мэргэжлээрээ 20-иос дээш жил ажилласан/ иргэдэд үзүүлэх эмнэлгийн үйлчилгээг найдвартай, түргэн шуурхай явуулж, орчин үеийн түвшинд хүргэхийг зорьж байна.

Гэтэл Эрүүл мэндийн сайд Т.Ганди нь 2005 оны 9 дүгээр сарын 20-ны өдөр 230 дугаартай тушаал гэнэт гаргаснаар бидний хууль ёсны эрх ашгийг зөрчиж, хувийн хэвшлийн эдгээр 15 эмнэлгийн байгууллагыг бүгдийг нь төрийн өмчийн эмнэлгүүдийн нэг нэг өрөөнд тараан байршуулахаар заах, эмчлэгч болон үйлчлүүлэгч нарын хэн хэнийх нь эрх ашгийг ноцтой зөрчсөн шийдвэр гаргасан. Энэ тушаалын дагуу манай эмнэлгүүд нэг нэг өрөөнд орох аваас урьд үзүүлж байсан эмнэлгийн үйлчилгээ бүрэн зогсож, хүний дарамт үзэх, чагнахаас хэтрэхгүй байдалд хүрэх юм.

Бид Эрүүл мэндийн сайд Т.Гандигийн дээрх хууль бус ажиллагааг таслан зогсоож өгөхийг хүссэн өргөдлөө Засгийн газарт 2005 оны 9 дүгээр сарын 23-ны өдөр өгсөн боловч Засгийн газраас бидний өргөдөл, хүсэлтийг шалгаж үзэлгүй, хариу өгөлгүй байсаар 2005 оны 9 дүгээр сарын 29-ний өдөр 209 дүгээр тогтоол гаргалаа. Энэ нь сайд

Т.Гандигийн хууль бус шийдвэрийг нягтлан шалгаж үзэлгүйгээр, өөрөөр хэлбэл, Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 6 дугаар заалт, 7 дугаар зүйлийн 2 дахь заалтыг зөрчсөнөөр Засгийн газар нь Үндсэн хуулийн Тавдугаар зүйлийн 2 дахь заалт "Төр нь нийтийн болон хувийн өмчийн аливаа хэлбэрийг хүлээн зөвшөөрч, өмчлөгчийн эрхийг хуулиар хамгаална", Арван дөрөвдүгээр зүйлийн 2 дахь заалт "Хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаж үл болно. Хүн бүр эрх зүйн этгээд байна", Арван зургадугаар зүйлийн 12 дахь заалт "Төрийн байгууллага, албан тушаалтанд өргөдөл, гомдлоо гаргаж шийдвэрлүүлэх эрхтэй. Төрийн байгууллага, албан тушаалтан нь иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн дагуу шийдвэрлэх үүрэгтэй" гэсэн заалтыг тус тус зөрчлөө.

Сайд Т.Гандийн саналыг үндэслэн насжилтыг судлах төвийг Эрүүл мэндийн үйлчилгээний II төвийн байранд оруулахаар гаргасан Засгийн газрын дээрх тогтоол хэрэгжих аваас эмнэлгийн үйлчилгээний нэгдсэн цогцолбор төв болж байсан хувийн хэвшлийн 15 эмнэлгийн байгууллага байргүйгээс ажиллах боломжгүй болж түүнд хэвтэн үйлчлүүлэгч нарын эрх ашиг зөрчигдөхөд хүрэх юм. Засгийн газар нь эмнэлгийн үйлчилгээг хувийн, улсын гэж ялган үзэж, Улсын Их Хурлаар 2004 онд баталсан Монгол Улсын Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт заасан зорилт, тухайлбал, "...иргэддээ үйлчлэх төрийн байгууллага, албан хаагчдын хариуцлага, чадавхийг дээшлүүлж, шийдвэр гаргах бүх түвшинд иргэд, олон нийтийн оролцоог нэмэгдүүлж, ил тод байдлыг хэвшүүлэн төрийн үйлчилгээг чанарын шинэ шатанд гаргах, хувийн салбарын өсөлтийн гол хөдөлгөгч хүч болгох, эдийн засгийн тогтвортой өндөр өсөлтийг хангах, мэдлэг, мэдээлэлд тулгуурласан шинэ зах зээл нээхийг дэмжих", мөн "Нийгмийн бодлого" бүлгийн 5 дахь заалтын "...Эрүүл мэндийн салбарын менежментийг боловсронгуй болгож, улсын болон хувийн эмнэлгийн оношлогоо, эмчилгээний чадавхийг сайжруулах, ялангуяа орчин үеийн иж бүрэн оношлогооны төвийг нийслэл хот болон бүсийн төвүүдэд байгуулах санаачлагыг дэмжинэ, ...Клиникийн болон төрөлжсөн нарийн мэргэжлийн эмнэлгүүдийн менежментийг боловсронгуй болгох" зэргийг хэрэгжих боломжгүй болгож байна. Энэ нь Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2 дугаар заалт "шинжлэх ухаан, технологийн нэгдсэн бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл, улсын төсөв, зээл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж Улсын Их Хуралд өргөж, гарсан шийдвэрийг биелүүлэх" гэсэн заалтыг зөрчлөө.

Засгийн газар нь 2005 оны 209 дүгээр тогтоолын 3 дугаар заалтыг хэрэгжүүлснээс гарах үр дагаврыг шийдвэрлээгүй юм. Энэ нь Үндсэн хуулийн Арван есдүгээр зүйлийн 2 дахь заалт "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна" гэсэн заалтыг зөрчлөө. Иймд Засгийн газрын 2005 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн 209 дүгээр тогтоолын 3 дахь заалт, түүнийг гаргахтай холбоотой үйл ажиллагаа Монгол Улсын Үндсэн хуулийн дээр дурсан заалтуудыг зөрчсөн эсэхийг тогтоож өгнө үү" гэжээ.

***Мөн Иргэн Д.Оюун, Я.Эрдэнэ нар Үндсэн хуулийн цэцэд 2005 оны 11 дүгээр сарын 1 1-ний өдөр ирүүлсэн нэмэлт тайлбартаа:***

Нэр бүхий 15 эмнэлгийн байгууллагын гаргасан нэхэмжлэлийн дагуу Нийслэлийн захиргааны хэргийн шүүхийн 2005 оны 11 дүгээр сарын 9-ны өдрийн 137 дугаартай шүүгчийн захирамжаар Эрүүл мэндийн сайд Т.Гандигийн 2005 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн 230 дугаартай тушаал хүчингүй болсныг батласнаар дээрх тушаал хууль илтэд зөрчсөн болох нь шүүхээр нотлогдсон.

Засгийн газрын дээрх үйл ажиллагаа нь Засгийн газрын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 3 дахь заалт, Үндсэн хуулийн Далдугаар зүйлийн 1 дэх заалт "Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино", Нэгдүгээр зүйлийн 2 дахь заалт "Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн" гэснийг тус тус зөрчлөө.

Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 6 дахь заалт "эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах эрхтэй..." гэсэн заалтыг зөрчин, иргэдийн энэ эрхийг нь хөндөн Засгийн газар Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3 дахь заалт, 4.2.2 дахь заалт, Засгийн газрын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 4 дэх заалтыг тус тус зөрчиж Үндсэн хуулийн

Тавдугаар зүйлийн 2 дахь заалт, Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт "Үндсэн хууль, бусад хуулийн биелэлтийг улс даяар зохион байгуулж хангах" гэснийг тус тус зөрчлөө" гэж нэмж дурдсан болно.

Мөн иргэн Д.Оюун, Я.Эрдэнэ нар 2006 оны 2 дугаар сарын 21-ний өдөр бичсэн тайлбартаа Засгийн газрын 2005 оны 209 дүгээр тогтоолын 3 дахь заалт Эрүүл мэндийн тухай хуулийн болон Засгийн газрын мөрийн хөтөлбөрийн зарим заалтыг зөрчсөн гэжээ.

***Хоёр. Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд Монгол Улсын Засгийн газрын итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр томилогдсон, Эрүүл мэндийн яамны төрийн нарийн бичгийн дарга Ц.Содномпил тайлбартаа:***

"Монгол Улсын Их Хурлын 2004 оны 24 дүгээр тогтоолоор батлагдсан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт ахмадад зориулан үйлчилгээ үзүүлэх, тэдний эрүүл мэндийг хамгаалах талаар тусгагдсан заалтууд, "Ахмад настны эрүүл мэнд, нийгмийн хамгаалал үндэсний хөтөлбөр батлах тухай" Засгийн газрын 1998 оны 130 дугаар тогтоолын Геронтологийн төв байгуулах заалт, Монгол Улсын Ерөнхий сайд Ц.Элбэгдоржоос "Настнуудын аж байдлыг сайжруулах тухай" 2005 оны 02 дугаар сарын 04-ний өдрийн 3Г/74 тоот албан бичгээр өгсөн үүрэг зөргийг хэрэгжүүлэхийн тулд Геронтологийн төв байгуулах асуудлыг Эрүүл мэндийн сайд Засгийн газрын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 5 дахь хэсгийн 14, 29 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 5, 6, 7-д заасны дагуу санаачлан Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлсэн. Дээрх асуудлыг Засгийн газрын хуралдаанд оруулсан, хэлэлцсэн үйл ажиллагаа Засгийн газрын тухай хууль, журамд нийцсэн тул Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 2 дахь хэсгийн 6 дугаар заалтыг зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй юм.

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Эрүүл мэндийн үйлчилгээний II төвийн байр нь төрийн өөрийн өмч тул хувийн хэвшлийн эмнэлгүүдийн өмчийн асуудлыг Засгийн газрын 2005 оны 209 дүгээр тогтоол хөндөөгүй юм.

Эрүүл мэндийн үйлчилгээний II төвийн байр нь хувийн хэвшлийн эмнэлгүүдийн байр биш, уг байгууллагууд нь зөвхөн төрийн өмчийг түрээслэгчид юм. Түрээсийн гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхгүй, төрийн өмчийн байрыг тэдгээр эмнэлгүүд нь өнөөдрийг хүртэл чөлөөлөхгүй байгаа нь төрийн өмчлөх эрхийг зөрчиж байгаа үйлдэл мөн.

Геронтологийн төв байгуулах тухай Засгийн газрын тогтоол нь Засгийн газрын үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, Ахмад настны эрүүл мэнд, нийгмийн хамгаалал үндэсний хөтөлбөрийг хэрэгжүүлэх хүрээнд гарсан шийдвэр бөгөөд Засгийн газрын тухай хуулийн 7.2 дахь заалтыг зөрчсөн гэх үндэслэл болохгүй байна. Дээрх тогтоол нь Засгийн газрын тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн хүрээнд гарсан.

Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 2 дугаар заалт нь Засгийн газрын 2005 оны Геронтологийн төв байгуулах тухай 209 дүгээр тогтоолын 3 дахь заалт буюу Геронтологийн төвийг Эрүүл мэндийн үйлчилгээний II төвийн байранд байршуулах ажлыг зохих журмын дагуу зохион байгуулахыг Төрийн өмчийн хороо /З.Энхболд/, Эрүүл мэндийн сайд Т.Гандид тус тус үүрэг болгосугай гэсэн заалттай огтхон ч хамааралгүй байна.

Иймээс Засгийн газрын 2005 оны 209 дүгээр тогтоол нь Эрүүл мэндийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд хууль, тогтоомжийн дагуу боловсрогдож гарсан учир Үндсэн хуулийн 38.2.2 дахь заалтыг зөрчсөн гэж үзэх үндэслэл болохгүй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 19.3-т Хүн эрх, эрх чөлөөгөө эдлэхдээ үндэсний аюулгүй байдал, бусад хүний эрх, эрх чөлөөг хохироож, нийгмийн хэв журмыг хохироож болохгүй гэж заасан бөгөөд Геронтологийн төвийн байранд байрлаж байгаа хувийн хэвшлийн эмнэлгүүд нь /нэхэмжлэгч тал/ зохих шийдвэр, гэрээнд заасан нөхцөлийн дагуу гэрээ цуцлах мэдэгдэл, байрлах байрыг нь олж өгсөөр байтал Засгийн газрын тогтоол, Төрийн өмчийн хорооны шийдвэрийг үл хүндэтгэн Төрийн өмчийн байрыг суллахгүй байгаа нь ахмад настанд үзүүлэх эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ, монгол хүний хөгшрөлтийн шалтгаан, эрүүл мэндэд нөлөөлөх хүчин зүйлийг судлах зэрэг зорилгоор Засгийн газрын тогтоолоор байгуулагдсан Геронтологийн төвийн үйл ажиллагаа тасарч олон зуун мянган ахмадуудын болон улс орны эрх ашигт ноцтой хохирол учрахад хүрээд байна.

Иргэн Д.Оюун, Я.Эрдэнэ нарын өргөдөлд "...Засгийн газар нь 2005 оны 209 дүгээр тогтоолын

3 дугаар заалтыг хэрэгжүүлснээс гарах үр дагаврыг шийдвэрлээгүй юм" гэсний хувьд Геронтологийн төв байгуулах тухай Засгийн газрын 2005 оны 209 дүгээр тогтоолын 3 дахь заалтаас гарах үр дагаврыг урьдчилан тооцож үзсэний үндсэн дээр Эрүүл мэндийн үйлчилгээний 2 дугаар төвд байрлаж байсан нэр бүхий 15 эмнэлэгт байр олж өгөх зорилгоор Эрүүл мэндийн сайдын Хувийн хэвшлийн эмнэлгүүдийг байршуулах тухай 2005 оны 230 дугаар тушаал гарсан.

Нэгэнт хувийн хэвшлийн эмнэлгүүд нь өөрсдийн эрх ашгийг хамгаалж гаргасан тушаалыг хүчингүй болгуулахыг хүссэн учир Эрүүл мэндийн сайд энэхүү тушаалаа өөрөө хүчингүй болгосон.

Тэдний эрх ашиг, үйлчлүүлэгч нарын эрх ашгийг хамгаалах зорилгоор гаргасан Эрүүл мэндийн сайдын 230 дугаар тушаалыг өөрсдөө тухайн үед нь хүлээн зөвшөөрөөгүй атлаа Үндсэн хуулийн цэцэд хандаж гаргасан өргөдөлдөө ...хувийн хэвшлийн 15 эмнэлгийн байгууллага байргүйгээс ажиллах боломжгүй болж, гудамжинд гарах, түүнд хэвтэн үйлчлүүлэгч нарын эрх ашиг зөрчигдөхөд хүрэх, мөн Засгийн газар Геронтологийн төв байгуулах тухай 209 дүгээр тогтоолын 3 дахь заалтаас гарах үр дагаврыг тооцож үзээгүй гэсэн нь Засгийн газраас шалтгаалаагүй. Энэ нь иргэдээс өндөр төлбөр авч үйлчилгээ үзүүлж буй хувийн байгууллагын өөрсдийн шийдвэрлэх ёстой асуудал гэж үзэж байгаа ба Үндсэн хуулийн 19.1 дэх заалтын "Төрөөс хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, хууль зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх үүргийг иргэнийхээ өмнө хариуцна" гэсэн заалтыг зөрчсөн гэж үзэх үндэслэл болохгүй байна.

Иймд дээрх хууль, тогтоомжуудын холбогдох заалтуудаас үзэхэд Засгийн газрын 2005 оны 9 дүгээр сарын 29-ны өдрийн 209 дүгээр тогтоолын 3 дахь заалт нь Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжид нийцэж байгаа болно" гэжээ.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд оролцсон иргэн Д.Оюун, Я.Эрдэнэ нарыг төлөөлж өмгөөлөгч Ц.Цэрэнжээ "Засгийн газар нь иргэдийн өмчлөх эрх, эрүүл мэндээ хамгаалуулах талаар тэдний өмнө хуулиар хүлээсэн үүргээ биелүүлээгүй учир Үндсэн хуулийн холбогдох заалтуудыг зөрчсөн гэж үзсэн болно. Засгийн газрын 2005 оны 209 дүгээр тогтоолын 3 дахь заалтыг хүчингүй болгоогүй тохиолдолд маргаан гарч, хувийн хэвшлийн эмнэлгийн эрх ашгийг хохироохоор байгааг анхаарч шийдэж өгнө үү" гэв.

Засгийн газрын итгэмжлэгдсэн төлөөлөгч Ц.Содномпил "Өргөдөлд зөрчигдсөн гэж үзэж буй Үндсэн хуулийн бүх зүйл, заалтыг Засгийн газар зөрчөөгүй болно. Тогтоолын заалтыг хэрэгжүүлэх нь Эрүүл мэндийн яам, Төрийн өмчийн хорооны шийдвэрлэх асуудал болно. Түүнийг бид зохицуулан шийдвэрлэх болно" гэв.

**ҮНДЭСЛЭЛ:**

Монгол Улсын Засгийн газрын "Геронтологийн төв байгуулах тухай" 2005 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн 209 дүгээр тогтоолын 3-т "Геронтологийн төвийг эрүүл мэндийн үйлчилгээний II төвийн байранд байршуулах ажлыг зохих журмын дагуу зохион байгуулахыг Төрийн өмчийн хороо /З.Энхболд/, Эрүүл мэндийн сайд Т.Гандид тус тус үүрэг болгосугай" гэж заажээ.

Нийслэлийн Сүхбаатар дүүргийн XI хорооны нутагт байрлах Эрүүл мэндийн үйлчилгээний II төвийн байшин нь төрийн өмчийн байр болох нь Төрийн өмчийн хорооны дарга Д.Сугарын 2006 оны 2 дугаар сарын 21-ний өдрийн 1³/211 дүгээр албан бичгээр ирүүлсэн тодорхойлолт, барилгын хувийн хэрэг бусад нотлох баримт, түүнчлэн өргөдөл гаргагч иргэн Д.Оюун, Я.Эрдэнэ болон Засгийн газрын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Эрүүл мэндийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Ц.Содномпил нарын хүлээн зөвшөөрч байгаагаар нотлогдож байна.

Дээр дурдсан болон хэргийн материалд авагдсан бусад нотлох баримт, маргагч талуудын тайлбарт дүгнэлт хийж үзэхэд Засгийн газрын 2005 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн 209 дүгээр тогтоолын 3 дахь заалт нь:

1.Хэн нэг өмчлөгчийн эрхийг зөрчөөгүй, хүнийг үндэс, угсаа, хэл, арьсны өнгө, нас, хүйс, нийгмийн гарал, байдал, хөрөнгө, чинээ, эрхэлсэн ажил, албан тушаал, шашин шүтлэг, үзэл бодол, боловсролоор нь ялгаварлан гадуурхаагүй, хүн бүр эрх зүйн этгээд байх болон эрүүл мэндээ хамгаалуулах, эмнэлгийн тусламж авах талаарх иргэний эрхийг зөрчөөгүй байна.

2."Үндсэн хууль, бусад хуулийн биелэлтийг улс даяар зохион байгуулж хангах болон шинжлэх

ухаан, технологийн нэгдсэн бодлого, улсын эдийн засаг, нийгмийн хөгжлийн үндсэн чиглэл, улсын төсөв, зээл, санхүүгийн төлөвлөгөөг боловсруулж Улсын Их Хуралд өргөж, гарсан шийдвэрийг биелүүлэх" тухай Засгийн газрын бүрэн эрхийг зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

3.Монгол Улсын Засгийн газар дээр дурдсан 209 дүгээр тогтоолд заасан асуудлыг хуралдаанд оруулж хэлэлцэн шийдвэр гаргахдаа Засгийн газрын тухай хуулийн 2 дахь хэсгийн 6, 7 дугаар зүйлийн 2, 3 дахь заалтыг зөрчсөн болох нь тогтоогдоогүй, ингэснээр Засгийн газар ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх зарчмыг зөрчсөн гэх үндэслэлгүй байна.

4.Монгол Улсын Засгийн газар Монгол хүний хөгшрөлтийн шалтгаан, эрүүл мэндэд нөлөөлөх хүчин зүйлийг судлах, нийгэм, хамт олонд тулгуурласан сэргээн засах төвийг байгуулж, түүнийг төрийн өмч болох Эрүүл мэндийн үйлчилгээний II төвийн байранд байршуулахаар шийдвэрлэснийг хүний эрх, эрх чөлөөг хангахуйц эдийн засаг, нийгэм, эрх зүйн болон бусад баталгааг бүрдүүлэх, хүний эрх, эрх чөлөөг зөрчихтэй тэмцэх, хөндөгдсөн эрхийг сэргээн эдлүүлэх талаар иргэнийхээ өмнө хариуцах үүргээ зөрчсөн гэж үзэх үндэслэлгүй байна.

5.Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэгт зааснаар сайдын тушаалыг хүчингүй болгох тохиолдолд Ерөнхий сайд захирамж гарган шийдвэрлэх үндэслэлтэй байна. Энэ утгаараа өргөдөл гаргагч нарын Эрүүл мэндийн сайдын 2005 оны 230 дугаар тушаалыг хүчингүй болгох тухай хүсэлтийг Засгийн газар шийдвэрлэж өгөөгүй гэсэн нь Ерөнхий сайдын эрх мэдэлд хамаарах асуудал бөгөөд өргөдөл гаргагч иргэдээс Үндсэн хуулийн цэцэд 2005 оны 12 дугаар сарын 14-ний өдөр гаргасан өргөдлийн агуулгатай давхацсан, Үндсэн хуулийн цэцийн гишүүний 2006 оны 2 дугаар сарын 02-ны өдрийн 5/10 дугаар тогтоолоор шийдвэрлэгдсэн асуудал болох өөрөөр хэлбэл, уг асуудлаар Үндсэн хуулийн цэцийн урьд гарсан хүчин төгөлдөр шийдвэртэй байгаа нь тогтоогдож байна.

Харин Засгийн газрын "Геронтологийн төв байгуулах тухай" 2005 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн 209 дүгээр тогтоолын 3 дахь заалтыг хэрэгжүүлэх явцад иргэдийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөнөөс нэр бүхий иргэд Үндсэн хуулийн цэцэд өргөдөл гаргахад хүргэсэн байна.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 1, 2 дахь заалтыг удирдлага болгон

**ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:**

1. Монгол Улсын Засгийн газрын 2005 оны 9 дүгээр сарын 29-ний өдрийн 209 дүгээр тогтоолын "Геронтологийн төвийг Эрүүл мэндийн үйлчилгээний II төвийн байранд байршуулах ажлыг зохих журмын дагуу зохион байгуулахыг Төрийн өмчийн хороо /З.Энхболд/, Эрүүл мэндийн сайд Т.Гандид тус тус үүрэг болгосугай" гэсэн 3 дахь заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2, Тавдугаар зүйлийн 2, Арван дөрөвдүгээр зүйлийн 2, Арван зургадугаар зүйлийн 6, 12, Арван есдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Гучин наймдугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, 2, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийг зөрчөөгүй байна.

2. Энэхүү дүгнэлтийг хүлээн авснаас хойш Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд заасны дагуу 15 хоногт багтаан хянан хэлэлцэж, хэрхэн шийдвэрлэсэн тухай хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

| | |
|---|---|
| **ДАРГА** | **Ж.БЯМБАДОРЖ** |
| **ГИШҮҮД** | **Л.РЭНЧИН** |
| | **П.ОЧИРБАТ** |
| | **Ч.ДАШНЯМ** |
| | **Ц.САРАНТУЯА** |

Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас гаргав.
**Хаяг: <<Төрийн мэдээлэл>>** эмхтгэлийн зөвлөл.
Улсын Их Хурлын Тамгын газрын Хэвлэх хэсэгт хэвлэв.
Улаанбаатар-12
Төрийн ордон
☎ 265958
Индекс 14003
Хэвлэлийн хуудас 4
☎ 329487